

2013 оны Хуваалцах цагийн хөтөлбөр

Би Бурханы хүүхэд

“Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь билээ” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”).





Хуваалцах цаг болон ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгын зааварчилгаа

Хүндэт Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн болон хөгжмийн удирдагч нар аа,

Энэ жил бид Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдэд тэд бол Бурханы хүүхдүүд гэдгээ мэдэхэд нь туслах ариун нандин адислал, боломжтой боллоо. Бид хүүхдүүд Тэнгэрлэг Эцэгийнхээ хайрыг мэдэрснээр энэхүү чухал үнэнээс суралцана гэдэгт найдаж байна. Та нар тэдгээр хуваалцах цагийн хөтөлбөрийн сургаалуудыг залбиралтайгаар зааснаар хүүхдүүдэд тэнгэрлэг зан байдал, зорилго, чадвараа ойлгоход нь тусалж чадна. Та тэдэнд Есүс Христэд итгэх итгэлээ болон Тэнгэрлэг Эцэгийн тэдэнд зориулсан төлөвлөгөөний талаарх гэрчлэлээ өсгөхөд нь тусалж чадна. Мөн та тэдэнд ирээдүйн төлөөх найдварыг өгч, Тэнгэрлэг Эцэгтээ эргээд очих зам дээрээ үлдэх тэдний хүслийг бэхжүүлж чадна.

Бэлтгэж, зааж, эдгээр үнэнүүдийг гэрчилснээр Сүнсний тусламжийг эрэлхийл. Таны шаргуу хичээл зүтгэлийн ачаар гэр бүлүүд адислагдах болно. Бид та нарт хайртай бөгөөд гайхамшигт хүүхдүүдийг маань хамгаалж, хүчирхэгжүүлэхийн тулд чин сэтгэлээсээ үйлчилж байгаад тань талархаж байна.

Хүүхдийн Хэсгийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөл

Хуваалцах цагийн зааварчилгаа

Сайн мэдээний зааварчилгаа

Долоо хоног тутам заагдах хуваалцах цагийн 15 минутын хичээлийг бэлтгэхдээ энэхүү товхимлыг ашиглана уу. Сүмээс зөвшөөрөгдсөн *Найз* эсвэл *Лиакхона сэтгүүлээс материал нэмж ашиглаж болно*. Дараах удирдамжууд хичээлээ төлөвлөж заахад тань тусална.

Заадаг хүүхдүүдээ хайрла. Хүүхдүүдийн сонирхол, авьяас билэг, хэрэгцээ шаардлагыг мөн тэдний нэрсийг мэддэг болсноор тэднийг хайрладгаа харуул.

Сургаалыг Сүнсээр заа. Хичээлээ бэлтгэх явцдаа заах зарчмуудынхаа талаар гэрчлэлээ бэхжүүлж, удирдамж хүлээн авахын төлөө залбир. Энэ нь Сүнслэгээр заахад тань туслана.

Суралцахыг урь. Энэхүү товхимол нь зөвхөн юу заахыг хэлээд зогсохгүй хэрхэн заах болон хүүхдүүдийг хичээлд идэвхтэй оролцуулахыг мэдэхэд тань тусалж чадна. Дараах гурван зүйлийг хичээл бүр дээр хэрэгжүүлснээр та сургаалыг илүү үр дүнтэйгээр зааж чадна.

1. Сургаалыг таньж мэдэх. Хүүхдүүдийн сурах сургаалыг ойлгомжтойгоор заах. Хэл яриагаараа болон үзүүлэн ашиглах замаар сургаалыг ойлгуулах. (Жишээ болгож хоёрдугаар сарын

дөрөвдэх долоо хоног, долдугаар сарын гуравдахь долоо хоногийн хичээлээс үз.)

2. Ойлголтыг нь урамшуулан дэмж. Дуулах, жүжигчилсэн тоглолт хийж үзүүлэх, судруудаас унших зэрэг олон янзын арга хэлбэрээр заах нь сургаалыг гүнзгий ойлгоход хүүхдүүдэд тусалдаг учир эдгээр аргуудыг онцгойлон анхаар.

3. Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж. Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх боломжийг хүүхдүүдэд олго. Тэд

тухайн сургаалтай холбоотой зорилго тавих болон үүний талаарх мэдрэмжээ илэрхийлж сурахад нь анхаарал хандуул.

Энэ товхимолд энэ жилийн зарим долоо хоногт заагдах бүтэн хичээлийг багтаасан болно. Бусад долоо хоногуудад бүтэн хичээлүүдийг бус зөвхөн санаануудыг оруулж өгсөн байгаа. Эдгээр санаанууд дээр өөрийнхөө санааг нэмж баяжуулан ашиглаарай.

Та энэхүү товхимолд багтсан зарим хичээлийг уншиж судлан санаа авах боломжтой. Тавдахь ням гарагт өмнө үзсэн хичээлүүдээ давтан бататгаж болно. Хичээлээ төлөвлөж, бэлтгэх үед чинь Сүнс таныг удирдан хөтөлнө.

**Долоо хоног бүр
(1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө,
(2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал,
(3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал.**

Интернетээс олж үзэх боломжтой

Зүйлс: Энэ гарын авлагад дурдсан мэдээлэл, үзүүлэн, эш татсан эх сурвалж материалуудыг интернетэд LDS.org-ын *Serving in the Church* хэсэгт байршуулсан байгаа.

Хичээлээ хөгжмийн удирдагчтай хамтран бэлтгэ. Дуу дуулах нь таны зааж буй сургаалыг тодотгож, баяжуулахад тань тусална. Та сайн мэдээний зарим хэсгийг заахдаа өөр ангийн багш, хүүхдүүдийг хичээлд оролцохыг урьж болно.

Зарим хичээлд Хүүхдийн Хэсэгт үг хэлэх зочин урихыг санал болгодог. Гэвч хэн нэгнийг урихынхаа өмнө бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авах хэрэгтэй.

Заах ур чадвараа сайжруулахад тань туслах хэд, хэдэн зөвлөгөө хичээлүүдэд орсон байгаа. Танд ойлгомжтой болгохын тулд тухайн хичээлийн үйл ажиллагааг харуулсан зургуудыг хичээлүүдэд багтаасан. Хэдийгээр заах ур чадвар чухал боловч таны сүнслэг бэлтгэл, гэрчлэл нь хүүхдүүдийн зүрх сэтгэлд сургаалуудыг бататгаж өгөх Сүнснийг урьдаг билээ.

Ариун ёслолын цуглаан дээр хийх танилцуулгын удирдамж

Ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгыг жил бүрийн дөрөвдүгээр улиралд бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн удирдлаган дор хийдэг. Тухайн жилийн эхээр бишопын зөвлөл эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн Хүүхдийн Хэсгийг хариуцсан зөвлөлтэй уулзаж урьдчилсан төлөвлөгөөний талаар ярилцах хэрэгтэй. Төлөвлөгөөг гүйцэд хийсэн үедээ зөвшөөрлийг ав.

Хүүхдийн хөтөлбөрийг сар тутмын хуваалцах цагийн сэдвүүдэд тулгуурлан төлөвлөсөн байх хэрэгтэй. Танилцуулгын хөтөлбөрт ашиглах зорилгоор жилийн туршид хүүхдүүдийн яриа болон хувийн туршлагыг тэмдэглэн авч болно. Тухайн жилийн турш сурсан зүйлээсээ хүүхдүүд хуваалцах үед цугларагсад хүүхдүүдийн зааж байгаа сайн мэдээний сургаалд анхаарал хандуулахад нь туслах арга замыг бодоорой. Бишопын зөвлөлийн нэг гишүүн товч дүгнэлтийг хэлж, цуглааныг хаана.

Энэхүү товхимолд ашигласан эх сурвалж материалууд

Тус товхимолд дараах товчлолуудыг хэрэглэсэн:

ХДН Хүүхдийн дууны ном

СМЗН Сайн мэдээний зургийн ном

TNGC Teaching, No Greater Call

Хичээлүүдэд зурагнууд ашиглахыг зөвлөсөн байгаа. Та зургуудыг Сайн мэдээний зургийн ном, Хүүхдийн Хэсгийн гарын авлагын зургийн цомгууд, Сүмийн сэтгүүл болон интернет дэх images.lds.org хаягаар орж авч болно.

Дуу дуулах цаг

Хүүхдийн Хэсгийн дуу хөгжим нь хүндэтгэлтэй нам гүм орчинг бүрдүүлж, сайн мэдээг заадаг төдийгүй хүүхдүүдэд Ариун Сүнсний нөлөөг болон дуу дуулснаар ирдэг баяр баяслыг мэдрэхэд нь тусална. Хуваалцах цагийн 20 минутыг дуу дуулах болон шинэ дуу заахад зориулах хэрэгтэй. Энэ хугацаа нь шинэ дуу заах болон хүүхдүүд дуулснаар сайхан мэдрэмж хүлээн авах хангалттай цаг юм.

Энэ товхимолд энэ жил хүүхдүүдийн сурах ёстой шинэ дууг багтаасан (28-р хуудсыг үз). Мөн энэ нь “Дуу хөгжмийг Хүүхдийн Хэсэгт хэрхэн ашиглах вэ” (26–27-р хуудсыг үз) гэсэн хэсгийг багтаасан бөгөөд дуунуудыг хүүхдүүдэд заах нэмэлт санаануудыг багтаасан байгаа (3, 11, 17-р хуудсыг үз).

Танилцуулгыг бэлтгэх явцдаа дараах удирдамжуудыг баримтал:

- Танилцуулгын бэлтгэл нь хичээл болон гэр бүлтэйгээ өнгөрүүлэх цагаас нь авахгүй байх ёстой.
- Үзүүлэн, хувцас өмсгөл мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэргийг ариун ёслолын цуглаанд ашиглах нь зохисгүй юм.



2013 оны сургалтын хөтөлбөр

Ерөнхий хөтөлбөр

Нярайн бүлэг: *Behold Your Little Ones*; Нарны цацраг: Хүүхдийн хэсэг 1; 3С 4–7; Хүүхдийн Хэсэг 3; Баатарчууд 8–11; Хүүхдийн Хэсэг 5

Үндсэн сургалтын хөтөлбөр

Нарны цацраг: Хүүхдийн хэсэг 1; 3С 4–7; Хүүхдийн хэсэг 3; Баатарчууд 8–11; Хүүхдийн хэсэг 7



Бэлтгэл: Хуваалцах цагаар заах бэлтгэлээ хангахдаа удирдамж болоод Сүнсний нөлөөг эрэлхийлэн залбир. Та Сүнсээр бэлтгэж, заахад Сүнс зааж буй зүйлсийг тань үнэн гэдгийг батлах болно. (TNGC, 13-г үз.)

Эх сурвалжууд:

Заахад тань туслах материалууд тухайлбал будах хуудас, түүх, үйл ажиллагаанууд зэрэг нэмэгдэл эх сурвалжуудыг Найз, Лиахона, нярайн ангийн гарын авлага, ба Сайн мэдээний зургийн номоос авч болно. Эдгээр эх сурвалжуудыг ашиглан хичээлээ баяжуулан дэлгэрүүл. Мөн сайн мэдээний онцгой сэдвүүдээр өгөгдсөн эх сурвалжуудын жагсаалтыг Найз болон friend.lds.org дээрээс олж болно. Хүүхдүүдэд заахын тул эдгээр эх сурвалжийг хэвлэн авч, ашиглаж болно.

Би Бурханы хүүхэд, Түүнд надад зориулсан төлөвлөгөө бий

Дуулал: “Би Бурханы хүүхэд”
(ХДН, 2–3)

Нэг жил үргэлжлэх үйл ажиллагаа: Бурхан танд хайртай гэдгийг олж мэдсэн арга замаа товч хуваалц. Жижиг биетийг (даавуун бөмбөг, шош, жижигхэн чулуу гэх мэт) цэвэрхэн шил эсвэл саванд хий. Жилийн турш Бурхан тэднийг мэддэг бөгөөд тэдэнд хайртайг хэрхэн олж мэдсэн арга замуудаа хуваалцахыг хүүхдүүдээс хүс. Хүүхдээс ямар нэгэн зүйл хувцаалцах бүртээ жижиг шил эсвэл саванд жижиг биетийг хийхийг хүс. Савыг ойр ойрхон шалгаж, Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртайгаа хэр олон арга замаар харуулдгийг олж мэд.

Хүүхдийн хэсгийнхээ хүүхдүүдийн тоонд тааруулж үйл ажиллагаануудыг төлөвлө.

Томоохон Хүүхдийн Хэсгийг бүлгүүдэд хувааж, судар уншуулах нь илүү олон хүүхдэд оролцох боломжийг олгодог. Та бүх хүүхдүүдийг хичээлд оролцуулахын тулд Хүүхдийн Хэсгийг жижиг бүлэг болгон хуваах шаардлагагүй.

“Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг” (Ром 8:16).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Бурхан бол миний Тэнгэрлэг Эцэг. Тэр намайг мэддэг бөгөөд надад хайртай.

Сургаалыг таньж мэд (тааварт тоглоом тоглох): Та бидэнд хайртай, бидний хүн нэг бүрийг мэддэг, бидэнд тусалдаг, биднээс хол амьдардаг хэн нэгний тухай бодож байгаагаа хүүхдүүдэд хэл. Тэднээс хэний тухай бодож байгааг таахыг хүс (Тэнгэрлэг Эцэг). Тэнгэрлэг Эцэгтэй бид хэрхэн холбогддогийг ярилц. Хүүхдүүдээс “Бурхан бол миний Тэнгэрлэг Эцэг. Тэр намайг мэддэг бөгөөд хайрладаг” гэж давтан хэлэхийг хүс.

Ойлголтыг нь урамшуулан дэмж (судруудаас унших): Хүүхдүүдийг бүлэг болгож хуваа. Бүлэг бүрээр Инос 1:5, Мосе 1:6, Иосеф Смит—Түүх 1:17-г уншуулж, Их Эзэн бошиглогч нэг бүрийг хэрхэн дуудсан тухай ярилц. “Хэрэв Тэнгэрлэг Эцэг чам дээр ирсэн бол чамайг юу

гэж дуудах байсан бол?” гэж хүүхдүүдээс асуу: Бурхан хүн нэг бүрийг нэрээр нь мэддэг гэдгийг гэрчил.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (дуу дуулах): Хүүхдүүдийг “Би Бурханы хүүхэд” (ХДН, 2–3) эсвэл “Эцэг минь амьдыг би мэднэ” (ХДН, 5) дууллыг дуулангаа тойрог болон зогсож, Хүүхдүүдийн төлөөх Бурханы хайрыг төлөөлсөн зүйлсийг бие биедээ дамжуулахыг хүс. Төлөөлж буй зүйлс нь судрууд, ариун ёслолын зураг, жимс, гэр бүлийн зураг байж болно. Хүүхдүүдийг гэнэт зогсоож, төлөөлж буй зүйлийг барьж байгаа хүүхдээс Бурхан өөрт нь хайртайг мэдсэн нэг арга замыг хуваалцахыг хүс. Цаг байвал үргэлжлүүлэн хий.


Хоёрдахь мөн гуравдахь долоо хоног: Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бол аз жаргалын төлөвлөгөө.

Сургаалыг таньж мэдэх:

Цаасан дээр “Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бол аз жаргалын төлөвлөгөө” гэж бич. Цаасыг хайрцганд хийж, бэлэг шиг боож багла. Бэлгийг барьж, хайрцган дотор тэднийг аз жаргалтай болгох ямар

нэгэн зүйл байгаа гэж хүүхдүүдэд хэл. Энэ юу болохыг таахыг хүүхдүүдээс хүс. Тэгээд бэлгийг нээж, цаасан дээрх өгүүлбэрийг хүүхдүүдэд уншиж өг. Биднийг аз жаргалтай болгож, Түүнтэй эргээд хамт амьдрах боломжийг олгодог нэгэн төлөвлөгөө Тэнгэрлэг Эцэгт байдгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (дуу дуулж, асуултуудад хариул): Доорх асуултуудын нэгийг нь бичсэн том цаасыг анги бүрт өг:



мөнх бус байдлын өмнөх амьдрал



Мөнх бус



мөнх бус байдлын дараах амьдрал



Миний амьдралд юу байдаг вэ мөн миний амьдрал хаанаас эхэлсэн бэ? Миний сонголт юу байсан бэ мөн би юуг эрэлхийлэх хэрэгтэй вэ? Би юуг дагаж, юунаас зуурах ёстой вэ? Хэрэв би Бурханы төлөвлөгөөг дагавал юут мэдрэх вэ?

“Бурханы зааснаар амьдарна, би” (ХДН, 164–65) дууллын эхний хоёр бадгийг дуулж, эхний асуултны хариултын талаар ярилц. Дууллын үлдсэн бадгуудыг дуулангаа, бусад асуултуудад хариул.

Ойлголтыг урамшуулан дэмж (өгүүлбэрийг дуусгах): Мөнх бус байдлын өмнөх оршихуй, мөнх бус амьдрал, мөнх бус амьдралын дараах амьдралыг төлөөлсөн зургуудыг өрөөний гурван өөр талд байрлуул. Цаасан дээр аз жаргалтай царай зур. Таныг аз жаргалтай царайг өргөх бүрт “Аз жаргалтай” гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс. Өмнөх амьдралын зурагны хажууд зогсоод Тэнгэр дэх Зөвлөгөөг тайлбарла. Хэрэв боломжтой бол таныг аз жаргалтай царайг өргөх үед “аз жаргалтай” гэдэг үг орсон өгүүлбэрийг дуусгахыг хүүхдүүдээс хүс. Жишээлбэл: “Тэнгэрлэг Эцэг биднийг аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Тэрээр дэлхийд ирж, бие махбодыг хүлээн авах бидэнд зориулсан төлөвлөгөөнийхөө тухай

бидэнд хэлсэн. Тэр хэрэв бид Түүний зарлигуудыг дагах юм бол аз жаргалтай байх болно гэж хэлсэн. Тэрээр бид бүгд төгс бус учраас аз жаргалтай байхын тулд Аврагч хэрэгтэй гэдгийг мэдэж байсан. Бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний тухай сонсоод маш их аз жаргалтай байсан бөгөөд баярлан хашгиралдсан!” Бусад бүлгүүд дээр очиж тайлбарлаж, аз жаргалын төлөвлөгөөг тодорхойлохдоо дээрхтэй адил үйл ажиллагааг хэрэгжүүл: “Чи өөрийнхөө гэр бүлд ирсэн, чамайг төрөхөд тэд маш их аз жаргалтай байсан.” “Бид зөв шударга сонголтыг хийснээр аз жаргалтай болдог.” “Бид гэр бүлтэйгээ болон Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй хамт селестиел хаант улсад үүрд мөнхөд амьдрахдаа аз жаргалтай байх болно.” Аз жаргалын төлөвлөгөөг хүүхдүүдийн нас, ойлголтоос шалтгаалж илүү нарийвчлан заа.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (зураг зурах): Хүүхэд бүрт аз жаргалтай царай зурсан мөн “Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бол аз жаргалын төлөвлөгөө” гэж бичсэн цаасыг өг. Тэднээс өөрсдийг нь аз жаргалтай болгодог Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний талаар ямар нэгэн зүйл зурахыг хүс. Эцэгийн төлөвлөгөө нь бидний мөнхийн аз жаргалын төлөө байдаг гэдгийг гэрчил.

Хайраа үзүүл: “Зааж буй тэдэндээ хайраа үзүүлэх нь тэднийг Сүнсэнд илүү дуулгавартай болгодог” (ТНГС, 31). Хүүхдүүдийн төлөө нэг бүрчлэн залбирснаар, тэдний хүсэл сонирхол, асуудлуудыг мэдэж, тэднийг нэрээр нь дуудаж, тэднийг анхааралтай сонсноор таны хүүхдүүдийг хайрлах хайр өсөх болно.

Дөрөвдэх долоо хоног: Надад сонгох эрх байдаг бөгөөд би сонголтынхоо төлөө хариуцлага хүлээдэг.

Сургаалыг таньж мэд: Нэгэн дээр нь “Надад сонгох эрх бий” гэж бичсэн харин нөгөөх дээр нь “Би сонголтынхоо төлөө хариуцлага хүлээдэг” гэж бичсэн хоёр том цаасыг бэлтгэ. Хүүхдүүдийг хоёр бүлэгт хуваа. Зургаан хүүхдийг ангийн самбарын өмнө гарч ирэхийг урь. Тэдний нэгнээс цаасыг өргөхийг хүсч, аль нэг бүлгээс босч зогсоод “Надад сонгох эрх бий” гэж хэлэхийг хүс. Өөр нэг хүүхдээс хоёрдахь цаасыг өргөж, үлдсэн бүлгээс босч зогсоод “Би сонголтынхоо төлөө хариуцлага хүлээдэг” гэж хэлэхийг хүс. Үүнийг хэд хэдэн удаа давтаж, бүлэг бүрээр хоёр өгүүлбэрийг хоёуланг нь хэлүүл.

Ойлголтыг нь урамшуулан дэмж (үр дүнгийн талаар ярилц): Хэрэв тэд хоол идэхгүй байж, халуун зууханд гараа хүргэхийг сонговол эсвэл сүмд явж, бусадтай эелдэг харьцахыг сонговол үр дүнд нь юу болохыг асуу. Тэнгэрлэг Эцэг биднийг хайрладаг бөгөөд биднийг зөв сонголт хийж, зөв сонголтынхоо адислалыг аваасай гэж хүсдэг гэдгийг тайлбарла.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тоглоом тоглох нь): Хоёр цаасан дээр хүүхдүүдийн хийж болох зарим сайн сонголт мөн зарим муу сонголтыг бич. Цааснуудыг хайрганд хий. Хүүхдүүдийг “сонголт” мөн “үр дүн” гэх хоёр багана болж зогсохыг урь. Багана бүр дэх эхний хүүхдийг самбар руу алхах зуур бүх хүмүүсээр “Зөвийг сонго” (Hymns, no. 239) дууллын эхний бадгийг дуулуул. “Сонголт” багана дээрх хүүхдээс цаасыг гаргаж, сонголтыг уншихыг хүс. Өөр хүүхдээр уг сонголтоос ирж болох үр дүнг хэлэхийг хүс. Бусад хүүхдээс хэрэв сайн сонголт байх юм бол эрхий хуруугаа дээш өргөж, муу сонголт байх юм бол эрхий хуруугаа доош харуулахыг хүс. Цаг байвал энэ мэтээр үргэлжлүүл.

Тэдний анхаарлыг татаж, суралцах үйл явцад оролцох боломжийг олгох үйл ажиллагаанд хүүхэд бүрийг идэвхтэй оролцуул.



Хөгжмийн удирдагчдад зориулсан тусламж

Хүүхдүүдээ “Би Бурханы хүүхэд” (ХДН, 2–3) дууллын дахилтыг тантай хамт дуулахыг мөн хэн нэгэн тэдэнд юу хийж өгвөл баярлах байсныг тодорхойлж буй үгсийг сонсохыг хүс. Тэдний хариултуудыг самбар дээр жагсаа (хөтлөх, удирдах, заах, туслах). Үг бүрийн талаар асуул

асуу. Жишээлбэл, “Хэн биднийг хөтөлдөг вэ” эсвэл “Та нар яагаад хэн нэгнийг чамайг хөтлөөсэй гэж хүсдэг вэ” гэж асуу. Эцэг эх, багш, удирдагч, бошиглогч, судрууд болон Тэнгэрлэг Эцэг рүү очих замаа олоход тусалдаг Ариун Сүнсстэй байхын адислалын тухай гэрчил.

Дэлхий Тэнгэрлэг Эцэгийн ХҮҮХДҮҮДИЙН ТӨЛӨӨ БҮТЭЭГДСЭН

Дуулал: “Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг”
(ХДН, 228–29)

“Дээр нь тэд оршин сууж болох дэлхийг бид хийх болно; мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно” (Абрахам 3:24–25).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Нэгдэх долоо хоног: Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийн удирдлаган дор дэлхийг бүтээсэн.

Сургаалыг таньж мэд (зурагнуудыг хар): Дэлхийн зургийг харуулж, хүүхдүүдээс хэн дэлхийг бүтээснийг асуу. Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийн удирдлаган дор дэлхийг бүтээсэн гэдгийг тайлбарла. Тэгээд Есүс Христийн зургийг үзүүлж, “Есүс Христ дэлхийг бүтээсэн” гэж хэлэхийг хүүхдээс хүс.

Ойлголтыг урамшуулан дэмж (зураг зурах): Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний нэг хэсэг нь бид бие махбодыг хүлээн авч, суралцаж, өсч хөгжихийн тулд дэлхийг бүтээх явдал байсан гэж хүүхдүүдэд хэл. Самбар дээр дугаарласан зургаан дугуй дүрсийг зур. Хүүхдүүдийг зургаан бүлэгт хувааж, бүлэг бүрээс Бүтээлтийн зургаан өдрийн талаарх дараах судруудаас нэгийг уншихыг хүс: Эхлэл 1:1–5 (нэгдэх өдөр); Эхлэл 1:6–8 (хоёрдахь өдөр); Эхлэл 1:9–13 (гуравдахь өдөр); Эхлэл 1:14–19 (дөрөвдэх өдөр); Эхлэл 1:20–23 (тавадахь өдөр); Эхлэл 1:24–31

(зургаадахь өдөр). Бүлэг бүрээс самбарын өмнө гарч ирээд, бусад хүүхдүүдэд уншсан судар дээр нь тухайн өдөр юу болсныг хэлэхийг хүсч, холбогдох дугуй дүрсэн дотор тухайн өдрийг төлөөлөх зургийг зур. Эхлэл 2:1–3-г хамтдаа унш. Бүтээлтийн өдөр бүр юу болсон тухай хүүхдүүдтэй хамт дүгнэлт хий.



Хоёрдахь долоо хоног: Уналт нь Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг байсан.

Сургаалыг таньж мэд (зураг харгах): Адам, Ева хоёрын зургийг үзүүл. Адам, Ева хоёр дэлхийд ирж, бие махбодыг хүлээн авсан анхны хүмүүс бөгөөд Еден гэдэг нэртэй цэцэрлэгт амьдарч байсан гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэд цэцэрлэгийг орхисны дараа бид дэлхийд ирэх боломжтой болсон гэдгийг тайлбарла; тэд цэцэрлэгийг орхисон үйл явцыг Уналт гэж нэрлэдэг. “Уналт нь Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг байсан” гэж самбар дээр бичээд үүнийг хүүхдүүдтэй хамт унш.

Ойлголтыг урамшуулан дэмж (сургаалыг яриуц): Самбар дээр хоёр дугуй зураад, нэгийг нь сүнсний дэлхий, нөгөөг нь дэлхий гэж тэмдэглэ. Адам, Ева хоёр Едений цэцэрлэгт байх үед бид сүнсний дэлхийд байсан гэдгийг тайлбарла. Зарим хүүхдүүдийн зургийг үзүүлж, самбар дээрх “сүнсний дэлхий” тойрогт байрлуул. Адам, Ева хоёр цэцэрлэгийг орхисны дараа бид

дэлхийд ирэх боломжтой болсон гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийн зургийг “дэлхий” тойрог руу шилжүүлж тавихыг нэг хүүхдээс хүс. Хэрэв хүүхдүүд Уналтыг сайн зүйл гэж бодож байгаа бол эрхий хуруугаа дээш өргөхийг хүс. Мөн нэг хүүхдээс яагаад гэдгийг нь асуу.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тохируулах тоглоомыг тоглох): Мөнх бус байдалд бидний авдаг зарим адислалуудыг төлөөлсөн үгнүүдийг бэлтгэ (бие махбод, гэр бүлүүд, сайн муугийн хоорондох сонголт, суралцах боломж, эрүүл мэнд болон өвчин, аз жаргал болон гуниг, зовлон гэх мэт). Цаасуудыг самбар дээр цааш харуулан тавь. Хүүхдүүдээс хоёр цаасыг эргүүлж хоорондоо таарч байгаа эсэхийг шалгахыг хүс. Хоорондоо тохирсон бол яагаад энэ нь адислал болохыг асуу.



Сүнсийг эрэлхийл:
Хуваалцах цагаар заах бэлтгэлээ хангахдаа удирдамж болоод Сүнсний нөлөөг эрэлхийлэн залбир. Та Сүнсээр бэлтгэж, заахад Сүнс таны зааж буй зүйлсийг үнэн гэдгийг батлах болно.



Гуравдахь долоо хоног: Би бие махбодыг өвлөж, соригдохоор дэлхийд ирсэн.




Хүүхдүүд та нарын хамгийн шилдэг үзүүлэн байж чадна.

Сургаалыг таньж мэд (үзүүлэнг үзэх нь):

“Би _____ өвлөж, соригдохоор дэлхийд ирсэн” гэж бич. Нэг хүүхдийг самбарын өмнө гарч ирээд самбар дээр эсвэл том цаасан дээр өөрийнхөө бие махбодыг зурахыг хүс. Зурсан зүйл нь юу болохыг хүүхдүүдээс асуу (бие махбод). Хоосон зайг бөглөж, хүүхдүүдтэй хамт өгүүлбэрийг хэл.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг урамшуулан дэмж (бие бялдрын үйл ажиллагаанд оролцох нь): Биеийн хэсгүүдийн зургийг харуулсан цаасан хүрд бэлтгэ (доорх жишээг үз). Бидний бие махбодын хийж чадах хэдэн зүйлсийн тухай



Цаасан хүрдийг харгахын тулд энд дарна уу.

Дөрөвдэх долоо хоног: Хэрэв би зарлигуудыг дагах юм бол Тэнгэрлэг Эцэгтэй дахин хамт амьдарч чадна.

Сургаалыг таньж мэд (дууллыг дуулах нь):

“Хэрэв _____ дагах юм бол Тэнгэрлэг Эцэгтэй эргээд хамт амьдарч чадна” гэж самбар дээр бич. “Зарлигуудыг дагацгаая” (ХДН, 146) дууллыг аял. Дууг санасан үедээ босоод хамт аялахыг хүүхдүүдээс хүс. “Тэнгэрлэг Эцэгтэй эргээд хамт амьдрахын тулд бид юу хийх ёстой вэ?” гэж асуу. Самбарын аль нэг хэсэгт “зарлигууд” гэж бич. Хүүхдүүдийг тантай хамт дуулахыг урь.

Ойлголтыг урамшуулан дэмж (зарлигуудын тухай ярилцах нь): Цөөхөн хэдэн хүүхдүүдээс гэр бүлээ аюулгүй байлгахын тулд аав ээжийнх нь гаргасан зарим гэр бүлийн дүрмээсээ хуваалцахыг хүс. “Дүрмүүдийг дуулгавартай дагах үед юу тохиолддог вэ?” гэж асуу. Тэдний санал зөвлөмжийг самбар дээр бич. Эцэг эхчүүд дүрэм журам гаргаснаар хайраа харуулдаг гэдгийг тайлбарла. “Бид Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дуулгавартай дагасан үед юу тохиолдох вэ” гэж асуу. Самбар дээр хүүхдүүдийн хариул-

ярилц. Тэдгээрийг тантай хамт хийхийг хүүхдүүдээс хүс (хуруугаа хөдөлгөх, хөлөө товших, эргэх гэх мэт). Бидний дэлхийд ирсэн зорилгуудын нэг нь бие махбодоо Тэнгэрлэг Эцэгийн сургаалыг дуулгавартай дагахад ашиглах эсэхээ харуулахын тулд соригдох гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс аль нэг хэсэг буюу биеийн эрхтэн рүү зааж, үүнийг Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагахад хэрхэн ашиглаж болохыг хэлэхийг хүс. (Хэрэв та цаасан хүрд хийх боломжгүй бол биеийнхээ өөр өөр хэсэг рүү зааж, хүүхдүүдээс Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагахад биеийн энэ хэсгийг хэрхэн ашиглаж болохыг асуу). Хүүхдүүдийг “I Have Two Ears” (ХДН, 269) дууллыг дуулахыг урь.

Зурагнууд: Хүүхдүүдийг зурсан зургаа үзүүлж, эцэг эхтэйгээ ярилцахыг урь. Энэ нь тэдэнд сурсан зүйлээ санахад нь тусална. Энэ нь мөн эцэг эхчүүдэд сайн мэдээний зарчмуудыг хүүхдүүдтэйгээ ярилцах боломжийг олгоно (TNGC, 167-2 үз).

тыг бич. Эцэг эхийнхээ гаргасан дүрэм журмыг дуулгавартай дагаснаар хамгаалагддагын адил Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дуулгавартай дагах нь тэднийг аюулгүй байлгадаг гэдгийг тайлбарла. Хэрэв бид зарлигуудыг дагавал Түүнтэй дахин хамт амьдрах боломжтой болно гэдгийг гэрчил.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (судар унших): Хүүхэд бүрт харандаа болон дөрөв хуваасан цаас тус бүр дээр дараах судруудыг нэг нэгээр нь бичээд өг: С ба Г 1:37, С ба Г 10:5, С ба Г 59:9–10, С ба Г 119:4. Хүүхдүүдээс судар бүрийг хамтдаа уншиж, судар дээр гарч байгаа зарлигуудын тухай ярилцаж, цаасан дээрээ зарлигуудын тухай зураг зурахыг хүс. Тэднийг дууссаны дараа зарлигуудыг дагах нь хэрхэн Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахад нь тэдэнд туслах талаар хуваалцахыг хүүхдүүдээс хүс.



Тараах материалыг харгахын тулд энд дарна уу.

Есүс Христ бол бидний Аврагч

“Анхаарагтун та нар эдгээр үгсийг. Болгоогтун, Бибээр Есүс Христ, дэлхийн Аврагч болой.” (С ба Г 43:34).

Дуулал: “If the Savior Stood Beside Me”

(энэ хөтөлбөрийн 28-р хуудас)

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Есүс Христ сайн мэдээг зааж, бидэнд үлгэр жишээ үзүүлсэн.

Сургаалыг таньж мэд (дуу дуулах): “Do As I’m Doing” (ХДН, 276) дууллыг хэд хэдэн удаа дуулж, өөр өөр хүүхдүүдийг гүйцэтгэх үйлдлээ сонгохыг хүс. Бид хэн нэгний үйлдлийг дагасан үедээ түүний үлгэр жишээг дагадаг гэдгийг тайлбарла. Хэн бидэнд дагах төгс үлгэр жишээ үзүүлснийг асуу (Есүс Христ). “Есүс Христ бидэнд үлгэр жишээ үзүүлсэн” гэж хамтдаа хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Ойлголтыг урамшуулан дэмж (судар унших): Дараах үйл явдлуудын тухай зургуудыг самбар дээр байрлуул: Христ баптисм хүртэж байна, Христ хүүхдүүдтэй хамт байна, Христ залбирч байна, Христ зааж байна. Дараах судруудын нэгийг хамтдаа уншиж, судар дээр Христ юу гэж зааж байгааг тайлбарлахыг хүүхдүүдээс хүс: Марк 16:15; Иохан 13:34–35; 3 Нифай 11:37; 3 Нифай 18:19. Зураг бүр рүү хуруугаараа зааж, хүүхдүүдийг таны уншсан судар дээр гарсан Христ бидэнд хийхийг заасан зүйлийг хамгийн сайн харуулж буй зураг руу заах үед босч зогсохыг урь. Бусад судрууд дээр мөн адил үүнийг хэрэгжүүл.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (зураг зурах): Хүүхэд бүрт цаас өгч, Христийн жишээг дагаж буй өөрсдийнхөө зургийг зурахыг хүс. Жишээлбэл, тэд өөрсдийгөө баптисм хүртэж байгаагаар мөн найздаа сайн мэдээг зааж, хэн нэгэнд тусалж байгаагаар төсөөлөн зурж болно. Цөөхөн хэдэн хүүхдээс зурсан зургаа бусадтайгаа хуваалцахыг хүсч, тэднийг зургаа ээж аавдаа үзүүлэхийг урамшуулан дэмж.

Хоёрдахь долоо хоног: Христийн Цагаатгалын ачаар би наманчилж, Бурхантай дахин хамт амьдарч чадна.

Сургаалыг таньж мэд (хоосон зайг бөглө): Хүүхдийн Хэсгийн хичээл эхлэхээс өмнө самбар дээр “Христийн _____ ачаар би _____, _____ дахин хамт амьдарч чадна” гэж бич. Цагаатгал, наманчлал, Бурхан гэдэг үгсийг гурван өөр цаасан дээр бичээд ангийн гурван сандал доор наа. Хүүхдүүдээс цаасыг олохыг хүсч, тэдгээрийг зөв байрлалынх нь дагуу самбар дээр наа. Өгүүлбэрийг бүгд хамтдаа унш.



Хүүхдүүд суралцах явцад идэвхтэй оролцсон тохиолдолд илүү хүндэтгэлтэй байдаг. Энэ үйл ажиллагааны үеэр хүүхдүүдийг хүндэтгэлтэйгээр босож, суухыг хүсэх нь тэдний анхаарлыг татахад тусална.

Сайн зан чанарыг урамшуулан дэмж:

Хүүхдүүдийн сайн зан чанарыг магтан сайшаах нь хүүхдийг муу зан чанараа зогсоохыг хүссэнээс илүү үр дүнтэй байдаг.

26:36.) Хүүхдүүдийг бүлэг болгон хувааж, бүлэг бүрээс судруудын аль нэгийг уншиж, асуултанд хариулахыг хүс. Бүлгүүдээс өөрсдийн хариултуудаа хуваалцаж, тохирох цаасыг зурагнаас холдуулахыг хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*биет үзүүлэнт хичээлийг бэлтгэх нь*): Цагаатгал, наманчлал зэрэг үгсийн утгыг хүүхдүүдтэй хамт ярилцаж, Цагаатгал биднийг хэрхэн адисалдаг болохыг тайлбарла (*True to the Faith: A Gospel Reference* [2004], 14–20, 132–35-г үз). Хүүхдүүдэд бэлэг харуул. Нэг хүүхдээс уг бэлгийг өөр нэг хүүхдэд өгч, хүлээн авч буй хүүхдийг бэлэг авахаас татгалзахыг хүс. Бидэнд өгч байгаа бэлгийг авахаас татгалзах үед бид тухайн бэлгийн адислалыг хүртэж чадахгүй гэдгийг тайлбарла. Таныг Сургаал ба Гэрээ 19:16-г уншиж байх зуур хүүхдүүдээс Цагаатгалын бэлгийг хүртэхийн тулд юу хийх ёстойг олж мэдэхийг хүс.



Судар унших үйл ажиллагааг бага насны хүүхдүүдэд тохируулахын тулд тэднээс судар уншиж байх зуур анхааралтай сонсож, тодорхой үг эсвэл өгүүлбэр сонссон үедээ босч зогсохыг хүс.

Гуравдахь долоо хоног: Есүс Христ амилсан болохоор би ч бас амилах болно.

Сургаалыг таньж мэд (*түүх сонсох нь*): Амилалтын тухай түүхийг ярьж өгөхийн тулд нярайн хүүхдийн гарын авлагын 123-р хуудасны зураглалыг ашигла (121-р хуудасны зааврыг үз) (see John 19:41–42; 20:1, 11–18). Есүс Христ амилах үед Түүний бие махбод болон сүнс дахин нэгдсэн бөгөөд энэ нь хүн бүрт амилах боломжийг олгосон гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээр “Есүс Христ амилсан болохоор би ч бас амилах болно” гэж хэлүүл.

Ойлголтыг урамшуулан дэмж (*мэдрэмжүүдийн тухай ярилцах нь*): Самбар дээр Есүсийг нас барах үед шавь нарынх нь мэдрэсэн мэдрэмжийг тодорхойлох үгсийг жагсаа (*зуниг, харуусал, сэтгэлээр унах гэх мэтчилэн*). Эдгээр үгсийн эсрэг утгатай үгсийг хэлэхийг хүүхдүүдээс хүсч (*баяр баясгалан, найдвар, итгэл гэх мэтчилэн*), тэдгээрийг самбар дээр бич. Тэдгээр

мэдрэмжүүд нь Есүсийг амилах үед шавь нарынх нь мэдрэсэн мэдрэмж гэдгийг тайлбарла. Бид амилах болно гэдгийг мэдсэнээр ирэх зарим адислалуудын тухай ярилц (Исаиа 25:8; Алма 22:14-г үз).

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*мэдрэмжүүдээ хуваалцах нь*): Самбар дээр “Есүс амилсанд би баяртай байдаг учир нь . . .” гэж бич. Хайртай нэгнээ алдсан тойргийн гишүүнийг Хүүхдийн Хэсэгт ирж, Амилалтанд яагаад талархаж явдгаа товч хуваалцахыг хүс. Хэрэв нас барсан хэн нэгнийг мэдэх хүүхдүүд байвал тэднээс нүдээ аниад тэр хүний тухай бодохыг хүс. Зарим хүүхдүүдээс босч зогсоод самбар дээрх өгүүлбэрийг бүтэн болгож, Амилалт тэдэнд ямар утга учиртай болохыг асуу.

Үзүүлэн: Хүүхдүүдэд харсан зүйл нь илүү тогтдог. Янз бүрийн үзүүлэнт материалууд нь хүүхдүүдийн сонирхолыг татдаг (TNGC, 89–90-г үз).

Дөрөвдэх долоо хоног: Есүс Христ бол бидний Аврагч.

Сургаалыг таньж, мэд (*“Аврагч” гэдэг үгийн талаар ярилц*): Бидний амьдралыг аварч болох хүмүүсийг төлөөлсөн ямар нэгэн биет зүйл эсвэл зураг харуулж (эмч, цагдаа, бие хамгаалагч гэх мэтчилэн), эдгээр нь биднийг хэрхэн аварч болохыг ярилц. Есүсийн зургийг үзүүлж, Тэр бол биднийг үхэл, нүглийн мөнхийн үр дагавараас аврах хүчтэй цорын ганц хүн гэдгийг тайлбарла. Самбар дээр “Есүс Христ бол бидний Аврагч” гэж бичиж, энэ өгүүлбэрийг хүүхдүүдтэй хамт уншиж, “Аврагч” гэдэг үгийг онцол.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг урамшуулан дэмж (*судрын түүхүүдийг сонсох нь*): Аврагчийн ачаар нүглүүдээсээ аврагдсан хүмүүсийн тухай судрын түүхийг хүүхдүүдэд хэлж өг (жишээлбэл, Бага Алма [Алма 36:6–24-г үз], Инос [Инос 1:1–8-г үз], Зиезром [Алма 15:3–12-г үз], Лемонайн эцэг [Алма 22:1–26-г үз], Есүст авчрагдсан хүн [see Лук 5:17–26-г үз]). Есүс Христийн Цагаатгалаар дамжин хүн бүр нүглүүдээсээ аврагдаж чадна гэдгийг тайлбарла. Есүс Христ бол бидний Аврагч гэдгийг гэрчилж, цөөхөн хэдэн хүүхдээс Түүний тухай гэрчлэлээ хуваалцахыг хүс.



Есүс Христ Өөрийн Сүмийг хожмын өдрүүдэд сэргээсэн

Дуулал: Хүүхдийн дууны ном -оос хүссэн дуугаа сонгон дуул.

“Бибээр сайн мэдээний бүрэн байдлаа өөрийн үйлчлэгч Иосефын гараар урагш илгээсэн буюу;” (С ба Г 35:17).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Гэрчил: Хүүхдүүдэд заахдаа сайн мэдээний үнэнүүдийн талаар гэрчлэлээ товч хуваалцах боломжийг ашигла (ХДН, 45-г үз).

Нэгдэх долоо хоног: Есүс Христ болон Түүний Төлөөлөгчид нас барсны дараа сайн мэдээний үнэнүүд алдагдсан.

Сургаалыг таньж мэд (ярилцах нь): Есүс Христийн дэлхий дээр байхдаа заасан зарим зүйлсийг нэрлэхийг хүүхдүүдээс хүс. Төлөөлөгчдийг томилж буй Христийн зургийг үзүүл. Христийг нас барж, амилсны дараа Түүний Төлөөлөгчид сайн мэдээг заасан боловч олон хүн тэднийг сонсоогүй бөгөөд удалгүй Төлөөлөгчид

нас барж, сайн мэдээний талаарх зарим чухал үнэнүүд дахин заагдаагүй гэдгийг тайлбарла. Самбар дээр “Есүс Христ болон Түүний Төлөөлөгчид нас барсны дараа сайн мэдээний үнэнүүд алдагдсан” гэж бич.

Ойлголтыг урамшуулан дэмж (зураг зурах нь): Урвалтын үеэр гээгдсэн эсвэл өөрчлөгдсөн зарим сайн мэдээний зарчмуудыг самбар дээр бич (жишээлбэл, баптисм, санваар, ариун сүмүүд, амьд бошиглогчид болон ариун ёслол). Ангийг жижиг бүлгүүдэд хуваа. Тэдгээр сайн мэдээний зарчмуудын нэгийг нь бичсэн цаасыг бүлэг бүрт өгч, тухайн зарчмыг төлөөлөх зургийг зурахыг хүүхдүүдээс хүс. Бүлэг бүрээс нэг хүүхдийг зурсан зургаа самбар дээр байрлуулахыг урь. Христ дэлхий дээр байхдаа тэдгээр сайн мэдээний чухал үнэнүүдийг заасан гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс нүдээ анихыг хүс. Бүх зурагнуудыг авч, нуу. Хүүхдүүдээс нүдээ нээхийг хүс. Есүс Христ болон Түүний Төлөөлөгчид нас барсны дараа сайн мэдээний үнэнүүд алдагдсан гэдгийг тайлбарла. Сайн мэдээ Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн гэж хүүхдүүдэд хэл. Зургуудыг самбар дээр дахин тавьж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд тэдгээр алдагдсан үнэнүүд бүгд байгаа гэдгийг гэрчил. (Дөрөвдэх долоо хоногт ашиглахын тулд зургуудыг хадгал.)



Зураг зурах нь хүүхдүүдэд сайн мэдээний зарчмуудын талаарх өөрсдийн ойлголтоо хуваалцах боломжийг олгодог. Хүүхдүүд өөрсдийнх нь зургийг үзүүлэнт материал болгон ашиглахад дуртай байдаг.

Хоёрдахь долоо хоног: Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христ Иосеф Смитэд үзэгдсэн нь.

Сургаалыг таньж мэд (сургийг харгах нь): Анхны Үзэгдлийн зургийг жижиг цаасуудаар бүтээж тавь. Хүүхдүүдээс цааснуудыг нэг нэгээр нь авахыг хүс. Ямар зураг байгааг мэдсэн үедээ чимээгүйхэн гараа өргөхийг хүүхдүүдээс хүс. Бүх цааснуудыг авсаны дараа хүүхдүүдээс зураг дээр юу болж байгааг хэлэхийг хүс.

Ойлголтыг урамшуулан дэмж (судар унших нь): Ариун ойн цоорхой дахь Иосеф Смитийн туршлагын тодорхойлолтыг судрын хаанаас уншиж болохыг хүүхдүүдэд харуул (Иосеф

Смит—Түүх 1:14–19). Ойн цоорхойд юу болсныг тодорхойлох хэдэн шүлгийг унш эсвэл хүүхдүүдээс уншихыг хүс. Та бага насны хүүхдүүдээс босч зогсох, мод шиг гараа дээшээ өргөх, залбирч байгаа мэт гараа атгах зэрэг энгийн үйлдлүүдийг хийхийг хүсч болно. Хэрэв тэд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф Смит дээр ирж, түүнтэй ярьж байхыг үзсэн бол юуг мэдрэх байсныг нь хүүхдүүдээс асуу. Энэ үйл явдлын ач холбогдлыг ярилц.


Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*гэрчлэлээ хуваалцах нь*): “The Sacred Grove” (ХДН, 87) дууллыг хүүхдүүдээр дуулуул. Дараа нь Тэнгэрлэг Эцэг, Есүс

Христ хоёр Иосеф Смитэд үзэгдсэн гэдгийг гэрчил. Цөөхөн хэдэн хүүхдээс Анхны Үзэгдлийн талаар гэрчлэлээ хуваалцахыг хүс.

Гуравдахь долоо хоног: Санваарын эрх мэдэл тэнгэрлэг элч нараар сэргээгдсэн.

Сургаалыг таньж мэд (*дуулал дуулах нь*): Хүүхдүүдээс ямар нэгэн маш чухал зүйлийг хэрхэн зарлах байсныг нь асуу. Олон жилийн өмнө ямар нэгэн чухал зүйлийг зарлахад бүрээ ашигладаг байсныг тайлбарла. “Санваар сэргээгдлээ” дууллыг хөгжимчин тоглож байх зуур хүүхдүүдээс нүдээ аниад бүрээ үлээж байгааг сонсож байна гэж төсөөлөхийг хүс (ХДН, 89). Хүүхдүүдээс дууллыг дуулж, энэ дуу ямар чухал захиасыг хүргэж байгааг олж мэдэхийг хүс. Цөөхөн хэдэн хүүхдээс энэ дууны утга учрыг тайлбарлахыг хүс.

Ойлголтыг урамшуулан дэмж (*зочин яриа өгөгчийг сонсох нь*): Хүүхдүүдэд Аароны болон Мелкизедек санваарын сэргээлтийн зургийг үзүүл. Аароны Санваар атгагчийг урьж, Аароны Санваарын сэргээлтийн



түүхийг ярьж өгөхийг хүс (С ба Г 13; Иосеф Смит—Түүх 1:68–72-г үз). Дараа нь Мелкизедек Санваар атгагчийг урьж, хүүхдүүдэд Мелкизедек Санваарын сэргээлтийн тухай хуваалцахыг хүс (С ба Г 27:12–13; Иосеф Смит—Түүх 1:72-г үз). Зурагнуудыг дахин үзүүлж, зурган дээрх хүмүүсийг нэрлэхийг хүүхдүүдээс хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*гэрчлэлээ хуваалцах нь*):

Аароны Санваар сэргээгдсэний ачаар одоо бидэнд байгаа нэг зүйлийг (жишээлбэл, баптисм, ариун ёслол) мөн Мелкизедек санваар сэргээгдсэний ачаар одоо бидэнд байгаа нэг зүйлийг (жишээлбэл, гишүүний баталгаа болон өвчтөнийг адислах) цаасан дээр бичихийг хүүхэд нэг бүрээс хүс. Зарим хүүхдүүдээс бичсэн зүйлээ хуваалцахыг хүс. Санваарын сэргээлтийн ачаар Тэнгэрлэг Эцэгээс ирдэг адислалуудад талархаж явдгаа илэрхийл.



Зочин яриа өгөгч Хүүхдийн хэсэгт тохируулан сонирхолтой, шинэ зүйлсийг нэмж болно.

Дөрөвдэх долоо хоног: Иосеф Смит Мормоны Номыг орчуулж, сайн мэдээний үнэнүүдийг сэргээсэн.

Сургаалыг таньж мэд, ойлголтыг урамшуулан дэмж (*ярилцах нь*): Хүүхдийн хэсгийн хичээлийн өмнө “Иосеф Смит Мормоны Номыг орчуулж, сайн мэдээний үнэнүүдийг сэргээсэн” гэж цаасан дээр бичээд дундуур нь хэд хэдэн хэсэг болгон хайчилж, эвлүүлэхэд тохиромжтой болго. Цаас бүрийн ар талд Мормоны Номын орчуулгатай холбоотой хүн эсвэл ямар нэгэн зүйлийн нэрийг нь бич (жишээлбэл, Иосеф Смит, Урим Туммим, Тэнгэр элч Моронай, алтан ялтсууд, Бурханы хүч, Оливер Каудери). Анги бүрт цаасны нэг хэсгийг өгч, цаасны ар талд байгаа хүн эсвэл зүйл Мормоны Номын орчуулгатай хэрхэн холбогдож байгааг ярилцахыг хүс. Анги

бүрийн хүүхдүүдийг самбарын өмнө гарч ирээд ярилцсан зүйлсээ хуваалцаж, цаасаа самбар дээр тавихыг хүс. Цааснуудыг эвлүүлж дууссаны дараа өгүүлбэрийг хамтдаа унш.

Ойлголтыг урамшуулан дэмж (*зочин яриа өгөгчийг сонсох нь*): Санваар атгагчийг урьж, Иосеф Смитийг үгээрээ илэрхийлж, тэр хэрхэн Мормоны Номыг орчуулсан түүхийг ярьж өгөхийг хүс. Түүнд нэгдэх долоо хоногт хүүхдүүдийн зурсан зарим зурагнуудыг өгч, сайн мэдээний зарчмууд хэрхэн Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн тухай хуваалцахыг хүс. Тэр хар урт зангиа зүүх зэргээр энгийн хувцаслаж болно. Түүнээс хүрмээ тайлаад, Иосеф Смитийн талаар гэрчлэлээ хуваалцахыг хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*санаануудаа хуваалцах нь*): Хэрэв хүүхдүүд нэгэн цагт алдагдаж, Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн үнэнүүдийг нэрлэж чадах бол босч зогсохыг хүс. Хэсэг хүүхдүүдийг урьж, бусадтай бодол санаагаа хуваалцахыг хүс. Сэргээгдсэн сайн мэдээ болон Мормоны Номын талаар гэрчлэлээ хуваалц.

Үйл ажиллагааг

тохируул: *Хуваалцах цагийн зарим үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохиромжтой байж болох ба бусад нь бага насны хүүхдүүдэд илүү тохиромжтой байж болно. Хичээлдээ төлөвлөхдөө зааж буй хүүхдийнхээ нас, авьяас чадварыг харгалзаж үзээрэй.*

**Иосеф Смит
Мормоны Номыг
орчуулж, сайн
мэдээний
үнэнүүдийг
сэргээсэн.**

Эвлүүлдэг зурагнуудыг харихын тулд энд дарна уу.

Сэргээгдсэн сайн мэдээний дагуу амьдрахыг бошиглогчид заадаг

Дуулал: Хүүхдийн дууны ном -оос хүссэн дуугаа сонгон дуул.

“Үнэхээр Эзэн БУРХАН зарц нар, эш үзүүлэгчиддээ Өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй.” (Амос 3:7).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.



Нэгдэх, хоёрдахь долоо хоног: Амьд бошиглогч Есүс Христийн удирдлага дор Сүмийг удирддаг.

Сургаалыг таньж мэд (зураг харж, тоглоом тоглох): Амьд бошиглогчийн зургийг үзүүл. Үсрэх, алгаа таших зэрэг энгийн үйлдлээр Хүүхдийн хэсгийг ээлжлэн удирдахыг хэсэг хүүхдүүдээс хүс. Бошиглогчийн зураг руу зааж, тэр бол Сүмийн Ерөнхийлөгч бөгөөд бид түүний биднээс хүссэн зүйлийг дагах ёстой гэдгийг тайлбарла. “Бошиглогч хэнийг дагадаг вэ?” гэж асуу. Есүс Христийн зургийг үзүүлж, бошиглогч Түүний удирдлага дор ажилладаг гэдгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (бошиглогчийн заасан зүйлсээс ярилцах нь): Ensign эсвэл Лиакхона зэрэг хамгийн сүүлийн чуулганы материалыг хүүхдүүдэд үзүүл. Ерөнхий чуулган дээр Есүс Христ биднээр хийлгэхийг хүсч байгаа зүйлсийг бошиглогч заадаг гэдгийг тайлбарла. Бошиглогчийн үгсээс өгүүлбэр сонгож, хүүхдүүдээс

чангаар уншихыг хүс. Хамтдаа бошиглогчийг дагахын тулд хүүхдүүдийн хийж болох зүйлсийн жагсаалтыг гарга.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (зураг зурах нь): Хүүхэд бүрт цаас өг. Хүүхдүүдээс цаасаа дундуур нь нугалахыг хүс. Нэг тал дээр нь бошиглогчийг зурж, нөгөө тал дээр нь бошиглогчийг дагадаг нэг арга замаа бичихийг хүүхдүүдээс хүс. Хүүхдүүдээс босч зогсоод зурагнуудаа барингаа “Бошиглогчийг дага” (ХДН, 110–11) дууллыг дуулахыг хүс.

Хоёрдахь долоо хоногт хамгийн сүүлийн ерөнхий чуулганаар бошиглогчийн заасан ямар нэгэн зүйлийг заа. Ашиглах үйл ажиллагаагаа төлөвлөхдөө бошиглогчийн сургаалыг хэрхэн зааж, хүүхдүүдэд үүнийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхэд нь хэрхэн туслах тухай бод.

Сургаалыг бататга:

Энэ сарын турш Есүс Христ бидэнд мэдүүлэхийг хүсч байгаа зүйлсийг бошиглогч бидэнд заадаг гэдгийг онцол. Бид бошиглогчийг дагасан үедээ Есүс Христийг дагадаг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Гуравдахь долоо хоног: Бошиглогчид аравны нэгээ төлөхийг надад заадаг.

Сургаалыг таньж мэд (судрыг уншиж, түүх сонсох нь): Хуучин Гэрээний Малахи бошиглогч хүмүүст аравны нэгээ төлөхийг заасан гэдгийг тайлбарла. Нэг хүүхэд Малахи 3:10 уншиж, бусад нь хэрэв бид аравны нэгээ төлвөл Их Эзэн бидэнд юуг амладаг тухай сонсоно. “Тэнгэрийн цонхнуудыг нээх” гэдэг нь аравны нэгээ төлнөөр хүлээн авдаг адислалыг хэлдэг гэдгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (биет зүйлийг ашигласан хичээлийг үзэх нь): 10 хүүхдийг самбарын өмнө гарч ирэхийг хүс. Хүүхэд нэг бүрт алим (эсвэл өөр жимс) өгч, тэднээс алимаа дээр өргөж, алимны мод болохыг хүс. Өөр нэг хүүхдээс алимнуудыг “гүүж” аваад сагсанд хийхийг хүс. Аравны нэг бол бидэнд байгаа зүйлийн аравны нэг буюу үүнийг ихэвчлэн мөнгөөр төлдөг боловч нэгэн цагт хүмүүс байгаа зүйлсээрээ төлж байсныг тайлбарла. Хүүхдээс хэдэн алимыг бишопт аравны нэг болгож өгөхийг асуу.



Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (аравны нэгийн талаар ярилцах нь): Аравны нэгийн хуудас болон дугуйг харуул. Аравны нэг төлөх үйл явцыг ярилц.

Аравны нэг төлснөөр тэдний гэр бүл хэрхэн адислагдсан тухай хуваалцахыг хүүхдүүдээс хүс. Аравны нэг төлөх бошиглогчийн зөвлөгөөг дагаснаар ирэх адислалуудын тухай гэрчил.



Дөрөвдэх долоо хоног: Бошиглогчид Мэргэн Ухааны Үгээр амьдрахыг заадаг.

Сургаалыг таньж мэд (судар унших нь): Аюулын талаар тэдэнд эцэг эх нь сэрэмжлүүлж байсан үеийг хэлэхийг хүүхдүүдээс хүс. Эцэг эх нь яагаад тэдэнд анхааруулсныг асуу. Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд бошиглогчдоороо дамжуулан аюулын талаар сэрэмжлүүлдэг гэдгийг тайлбарла. Сургаал ба Гэрээ 89:4-г уншихыг нэг хүүхдээс хүсч, энэ сэрэмжлүүлгийг юу гэж нэрлэдгийг бусад хүүхдүүдээс асуу. Бошиглогч Иосеф Смит Мэргэн Ухааны Үг хэмээх энэ анхааруулгыг Бурханаас илчлэлтээр хүлээн авсан гэдгийг тайлбарла.

олохыг хүс. Судрын эшлэлийг олсон хүүхдээс чангаар уншихыг хүс. Шүлэг бүр ямар утгатай болохыг ярилц. “Хүчтэй ундаа” нь согтууруулах ундааг харин “халуун ундаа” нь цай, кофег хэлж байгааг тайлбарлаарай.

Ойлголтыг урамшуулан дэмж (судар унших нь): Хүүхдийн Хэсгийн хичээлийн өмнө дараах судруудын эшлэлийг өөр өөр сандалны доор наа: С ба Г 89:7, С ба Г 89:8, С ба Г 89:9, С ба Г 89:10, С ба Г 89:12, С ба Г 89:16. Тэнгэрлэг Эцэг бидэнд бидний бие махбодыг өгсөн бөгөөд Тэр биднийг халамжлахыг хүсдэг; Тэрээр бидний бие махбодид ямар зүйлс тусалж, ямар зүйлс хордуулдаг болохыг мэдэхэд туслахын тулд бидэнд Мэргэн Ухааны Үгийг өгсөн. Хүүхдүүдээс сандалныхаа доод талыг харж, судрын эшлэлийг

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тоглоом тоглох нь): Бие махбодид муу, сайн хэдэн хэдэн төрлийн хоол, ундаа, зүйлсийн зургийг сагсанд хий. Нэг хүүхдээс сагснаас зураг сонгож, үүнийг бусад хүүхдүүдэд үзүүлэхийг хүс. Хэрэв тэр зүйл нь сайн байвал амаа ангайж, муу байвал амаа жимийхийг хүүхдүүдээс хүс. Сургаал ба Гэрээ 89:18–21-г уншиж, Мэргэн Ухааны Үгийн дагуу амьдрах бошиглогчийн зөвлөгөөг дагаснаар ирэх адислалуудын тухай ярилц.



Хүүхдүүд хөгжилтэй үйл ажиллагаа болон үйл хөдөлгөөнөөр дамжуулан сурч, хүндэтгэлтэй байж чадна.

Хөгжмийн удирдагчдад зориулсан тусламж

Энэ сарын дуу нь “Бурхан минь бошиглогч илгээсэн танд талархъя” (Нутис, no. 19) дуулал байж болно. Аль нэг дууллыг заахад ашиглагдах санаануудыг доор жагсаав. Энэ жишээнд үгтэй зурвасыг ашигласан боловч бага насны хүүхдүүдэд дууг заахдаа зураг ашиглаж болно.

Дууллын өгүүлбэр бүрийг өөр өөр өнгийн зурвасан дээр бич. Өгүүлбэр бүрийг хоёр хэсэгт хуваа. Дууллыг заахын тулд дараах санаануудын аль нэгийг нь ашигла:

1. Зурвас бүрийг ерөөнд тарааж байрлуул. Хүүхдүүд дууллыг тантай хамт дахин дахин дуулах хооронд өгүүлбэрийг зөв байрлалд оруулахыг хэсэг хүүхдүүдээс хүс. Өгүүлбэр бүрийг дуулж, ярилцаад дараа нь дууг бүхэлд нь дуул.
2. Самбар дээр байгаа зурвасаас эхэл. Хүүхдүүдтэй хамт дуул. Нэг хүүхдээс нэг зурвасыг авч дуулж, дууллыг дахин дуул. Бүх зурвасыг авч дуустал үргэлжлүүл.
3. Өгүүлбэр бүрийн эхний хэсгийг самбар дээр зөв байрлалд тавьж, хоёрдахь хэсгийг самбар дээр тарааж тавь. Өгүүлбэр бүрийн эхний хэсгийг дуулаад хүүхдүүдээс бадгийн хоёрдахь

Энэ үед	биднийг удирдан залах
бошиглогч илгээсэнд	баярлалаа
Оюун бодол,	санааг гийгүүлэх
сургаалаа өгсөнд тань	талархъя.
Өгөөмөр таны харамгүйгээр	өгсөн
адислалд	баярлан
Тушаалуудыг тань даган	тандаа үйлчлэх
хүсэл	бидэнд төрөх юм.

Үгтэй зурвасуудыг харахын тулд энд дарна уу.

хэсгийг олж, бадаг гэж юу болохыг тайлбарлахыг хүс.

4. Хүүхдүүдийг хоёр бүлэгт хуваа. Нэг бүлгээр өгүүлбэрийн эхний хэсгийг дуулуулж, өөр нэг бүлгээр хоёрдахь хэсгийг дуулуул. Бүлгүүдэд бадгийг сольж өгөөд дуулахыг хүс.

Дуу: “Намайг баптисм хүртэхэд” (ХДН, 103)

Би баптисм хүртэж, гишүүнээр батлуулснаар Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагана

“Та нар нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч, мөн Ариун Сүнсээр дүүргэгдэж болохын тулд, ... мөн надад ирж, мөн миний нэрээр баптисм хүрт.” (3 Нифай 30:2).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Хайраа үзүүл: Зааж байгаа хүүхдүүддээ хайраа үзүүлэхийн тулд хичээлд оролцож байгаа хүүхдүүдэд хэдийгээр тэдний хариулт нь зөв биш байсан ч чин сэтгэлийн магтаалыг хэл.

Нэгдэх долоо хоног: Би баптисм хүртэж, гишүүнээр батлуулснаар Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагана.


Хүүхдийн хэсгийн хичээлийн өмнө өөр өөр өнгийн цаасан дээр зурсан том хөлийн мөрийг хайчилж ав. Нэгэн дээр нь “баптисм хүртэж, гишүүнээр батлуулснаар” нөгөөх дээр нь “баптисмын гэрээгээ сахиснаар” гэж бич. Мөн том хөлийн мөртэй адил өнгөөр хэд хэдэн жижиг хөлийн мөр бэлтгэ. Дараах үгсийн аль нэгийг нь нэгдэх өнгийн хөлийн мөр бүр дээр бич: *найман нас, наманчлах, бишоптой ярилцах, ангижрал, санваарын эрх мэдэл, гэрээ, цагаан хувцас, Ариун Сүнс. Хоёрдахь өнгийн жижиг хөлийн мөр бүр дээр “Миний сайн мэдээний жишгүүд” дээрх жишгүүдийн аль нэгийг нь бич. Жижиг хөлийн мөр бүрийг ангид тарааж тавь.*

Сургаалыг таньж мэд: Самбар дээр “Би . . . Есүс Христийг дагана” гэж бич. Том хөлийн мөрүүдийг нэг нэгээр нь самбар дээр байрлуулж, өгүүлбэрийг хамтдаа унш. Эдгээр алхмууд нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд шаардлагатай алхмууд гэж тайлбарла. Хэрэв шаардлагатай бол хүүхдүүдэд баптисмын гэрээ гэж юу болохыг ойлгоход нь тусал.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг урамшуулан дэмж (тохируулах тоглоом тогло): Нэг хүүхдээс нэгдэх өнгийн хөлийн мөрийн аль нэгийг нь олохыг хүс. Түүнээс хөлийн мөр дээрх үгийг уншиж, тохирох том хөлийн мөрийн доор самбар дээр тавихыг хүс. Хүүхдүүдээс энэ нь

баптисм, гишүүний баталгаанд ямар үүрэгтэйг асуу. Нэгдэх өнгийн үлдсэн хөлийн мөр бүр дээр үүнийг давтан хий.

Нэг хүүхдээс хоёрдахь өнгийн хөлийн мөрийг олохыг хүс. Түүнээс хөлийн мөр дээрх үгийг ун-



Хөлийн мөрийг харахын тулд энд дарна уу.

шиж, тохирох том хөлийн мөрийн доор самбар дээр байрлуулахыг хүс. Хөлийн мөр дээрх сайн мэдээний жишгээр амьдрах нь хэрхэн хүүхдүүдэд баптисмын гэрээгээ сахихад тусалдаг тухай ярилц. Энэ мэтээр бусад хөлийн мөр дээр ажилла.

Хоёрдахь долоо хоног: Хэрэв би зохистой амьдрах юм бол Ариун Сүнс надад зөвийг сонгоход тусална.

Сургаалыг таньж мэд (дуу дуулах): Баптисм хүртсэний дараа бидэнд ямар бэлэг өгдөг вэ гэж хүүхдүүдээс асуу. “Ариун Сүнс” (ХДН, 105) дууллын хоёрдахь мөрийг дуул. Дуулахынхаа өмнө хүүхдүүдээс дараах асуултын хариултыг олж сонсохыг хүс: Ариун Сүнс бидэнд юу хийхэд тусалдаг вэ? Энэ намуухан, зөөлөн дуу хоолой нь Ариун Сүнс бөгөөд Тэрээр бидэнд зөвийг сонгоход тусалдаг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Ойлголтыг урамшуулан дэмж (биет үзүүлэнг хичээлийг үзэх нь): Бид өөрсдийн оюун санаан дахь бодол болон зүрх сэтгэл дэх мэдрэмжинд анхаарал хандуулснаар Ариун Сүнсний өдөөлтийг сонсож сурах ёстой гэдгийг тайлбарла (С ба Г 8:2). Нэг хүүхдээс зоосыг шилэн саванд хийж, сэгсрэхийг хүс. Хүүхдүүдээс энэхүү дуу авиаг хэр тод сонсож байгааг нь асуу. Хүүхдүүдээс халбага дүүрэн шороо, будаа, элс



Сургаалыг биет үзүүлэнг хичээлтэй холбох нь хүүхдүүдэд хичээлийг санахад тусалдаг.

эсвэл даавуун бөмбөгийг шилэнд хийхийг хүс. Эдгээрийг хийсний дараа нэг хүүхдээс шилийг сэгсрэхийг хүсч, хүүхдүүдээс эдгээр зүйлс нь дуу авианд хэр нөлөөлж байгааг асуу. Хүүхдүүд дуу авиаг сонсож чадахгүй болтол нь шилэн дотор тэдгээрээс нэмж хий. Үүнийг бидний амьдрал нүгэл, буруу зүйлсээр дүүрэх үед Ариун Сүнснийг сонсоход хэцүү болдогтой адилтга. Шилийг хоосолж, зоос дахин тод сонсогдож байгааг харуул. Зарлигуудыг дагаж, нүглүүдээ наманчлах нь бидэнд Ариун Сүнснийг сонсоход тусалдаг гэдгийг гэрчил.

Гуравдахь долоо хоног: Би ариун ёслолоос хүртсэнээр баптисмын гэрээнүүдээ шинэчилдэг.

Сургаалыг таньж мэд (зураг руу харарх):

Баптисм болон ариун ёслолын зургийг үзүүлж, энэ хоёр зураг хоорондоо хэрхэн холбогдож байгааг асуу. Бид баптисм хүртэхдээ Тэнгэрлэг Эцэгтэй гэрээнүүдийг хийдэг гэдгийг хүүх-



дүүдэд сануулж, бид ариун ёслолоос хүртэх үедээ баптисмын гэрээгээ шинэчилдэг гэдгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (сонсох мөн ярилцах нь): Таныг ариун ёслолын залбирлын дараах өгүүлбэрүүдийг унших зуур өөрсөд рүүгээ эсвэл тэнгэр рүү зааж, амлалтыг хэн өгдөгийг тодорхойлохыг хүүхдүүдээс хүс (С ба Г 20:77-г үз): “өөрсөдөө таны Хүүгийн нэрийг авч”; “үргэлж түүнийг санаж”; “түүний зарлигуудыг дагаж”; “түүний Сүнснийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж” гэсэн өгүүлбэр бүрийн утгыг ярилц.

Дөрөвдэх долоо хоног: Би наманчлах юм бол уучлагдаж чадна.

Сургаалыг таньж мэд (үгийг ойлгомжтой болгох нь): Наманчлах, уучлах гэдэг үгсийн утгыг тайлбарлахыг хүүхдүүдээс хүс. Анги бүрт дараах үгсийг тусад нь цаасан дээр бичиж, дугтуй дотор хийж өг: Би, наманчлах, юм, бол, уучлагдаж, чадна. Анги бүрийг тэдгээр үгсийг зөв байрлалд нь оруулахыг урь. Тэднийг дууссаны дараа хүүхдүүдээс өгүүлбэрийг хамтдаа хэлэхийг хүс.

Ойлголтыг урамшуулан дэмж (судрын түүхийг жүжжиглэж үзүүлэх нь): Үрэлгэн хүүгийн (Лук 15:11–24-г үз) тухай түүхийг аль болох их үйлдэл хийж өөрийн үгээр ярьж өг (жишээлбэл, хоёр хүүг дүрсэлж хоёр хуруугаа өргөх, өлсгөлөн байдлыг дүрсэлж гэдсээ илэх). Хүүхдүүдээс түүхийг сонсож, таны үйлдлийг дагаж

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (санаагаа хуваалцах нь):

Хүүхдүүдийг бүлгүүдэд хувааж, бүлэг бүрээс “Ариун Сүнс” дууллыг дуулах эсвэл үгийг нь хэлэх зуураа жижиг биетийг бие биендээ дамжуулахыг хүс. Гэнэт зогсоож, биетийг барьж байгаа хүүхдүүдээс Ариун Сүнснийг илүү тод сонсохын тулд хийх нэг зүйлийг хэлэхийг хүс. “Ариун Сүнс” дууллыг хамтдаа дуулж хичээлийг төгсгө.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (үйлдэл үзүүлэх нь):

Хүүхдүүдээс ариун ёслолын залбирал дээр гардаг гэрээ бүрийг тэдэнд сануулах үйлдлийн тухай бодохыг хүс. Жишээлбэл, гараа зүрхэн дээр тавих (өөрсөдөө Таны хүүгийн нэрийг авч); толгой руугаа заах (үргэлж түүнийг санаж); гараа ном шиг дэлгэх (түүний зарлигуудыг дагаж); өөрийгөө тэврэх (түүний Сүнснийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж). Дөрвөн амлалт бүрийг үйлдэлтэй нь хэд хэдэн удаа давт. Хүүхдүүдийг ариун ёслолын залбирлыг сонсоходоо тэдгээр үйлдлүүдийг оюун санаандаа бодож байхыг урамшуулан дэмж.



Бүх хүүхдүүдийг

оролцуул: Хүүхдүүд үйл хөдлөл, үйл ажиллагаагаар дамжуулан суралцаж, санадаг. Түүхийг тэдэнд ярьж өгч байх зуураа хүүхдүүдээр энгийн үйл хөдлөл хийлгэж идэвхтэй оролцуул.

Гэр бүл бол Тэнгэрлэг Эцэгийн ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГ ХЭСЭГ

Дуулал: “Гэр бүл үүрд хамт байж болно”
(ХДН, 188)



Үйл ажиллагааг

тохируулах нь: Нэгдэх

долоо хоногийн хоёрдахь үйл ажиллагаа нь бага насны хүүхдүүдэд илүү тохиромжтой. Арай том хүүхдүүдэд зориулж эдгээр гэр бүлийн талаар судруудаас заахыг төлөвлө.

Биет үзүүлэнт хичээлийг сонирхолтой хичээл зааж, хүүхдүүдийн анхаарлыг татаж, сайн мэдээний зарчмыг танилцуулахад ашиглаж болно (TNGC, 164-г үз).

“Гэр бүл Бурханаас заяагддаг” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”, 7-р догол мөр).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Нэгдэх долоо хоног: Тэнгэрлэг Эцэг намайг гэр бүлд ирэхийг төлөвлөсөн.

Сургаалыг таньж мэд: “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-г хүүхдүүдэд үзүүлж, энэ нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө нь Өөрийн хүүхдүүдэд дэлхийд ирж, гэр бүлтэй болох боломжийг олгодог гэж заадгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (зураг руу харах нь): Хүүхдүүдийг бүлэг болгон хувааж, бүлэг бүрт гэр бүлийн зургийг өг (жишээлбэл, Адам, Ева хоёр хүүхдүүдээ зааж байгаа [СМЗН, дугаар, 5], Христ Иайрийн охиныг өргөж байгаа [СМЗН, но. 41], Лихайн гэр бүл амлагдсан нутагт ирж байгаа [СМЗН, дугаар, 71], залбирч байгаа гэр бүл [СМЗН, дугаар, 112]). Бүлэг бүрээс зурган дээрх гэр бүлийн гишүүдийг олохыг хүс. Бүлэг бүрээс өөрсдийн зургийг өөр бүлгүүдэд үзүүлж, эцэг, эх, хүүхдүүдийг олж заахыг хүс. Хүүхдүүдээс энэ гэр бүлд хэдэн хүн байгааг хуруугаараа үзүүлэхийг хүс. Тэдний гэр бүл Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг гэдгийг хэл.


Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж: Хөвгүүдийг босохыг хүс. Тэд нэгэн өдөр зөв шударга гэр бүлийн эцэг болж чадна гэдгийг тайлбарла. Цөөхөн хэдэн хөвгүүнээс сайн эцэг байхын тулд хийх ёстой зүйлийн



Хэрэв та зураг болон бусад үзүүлэх материал ашиглавал хүүхдүүд илүү сайн сурч, удаан санах болно (TNGC, 176-г үз).

талаар хэлэхийг хүс. Охидуудыг босохыг хүсч, тэд зөв шударга гэр бүлийн эх болж чадна гэдгийг тайлбарла. Тэдний цөөхөн хэдээс нь сайн эх болохын тулд хийх ёстой зарим зүйлсийн талаар хэлэхийг хүс. Одоо байгаа өөрсдийн гэр бүлд аз жаргал авчрахын тулд хийж чадах зүйлсийнхээ талаар хуваалцахыг тэднээс хүс.

Хоёрдахь долоо хоног: Гэр бүлийн залбирал хийж, гэр бүлээрээ судар судалж, гэр бүлийн үдшийг хийх нь гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд маань тусална.



Сургаалыг таньж мэд, ойлголтыг урамшуулан дэмж (биет үзүүлэнт хичээлийг үзэх нь): Хүүхдэд багц савх бариул. Тэдгээр савх нь гэр бүлийн гишүүдийг төлөөлж байгааг тайлбарла. Гурван цаасан дээр “гэр бүлийн залбирал”, “гэр бүлээрээ судар судлах”, “гэр бүлийн үдэш” гэж бич. Тэдгээр үйл ажиллагаанууд нь хэрхэн гэр бүлийг хүчирхэгжүүлж, гэр бүлийг хамтад нь байлгадагийг асуу. Хүүхдүүдээс савхнуудыг цаасаар ороохыг хүс. Эдгээр үйл ажиллагаанууд нь бидний гэр оронд болон амьдралд Сүнсийг урьж, биднийг Тэнгэрлэг Эцэгт болон Есүс Христэд илүү ойртуулж, гэр бүлийг илүү хүчирхэг болгодог гэдгийг тайлбарла.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (зураг зурах нь): Хүүхдүүдэд цаас өгч, тэднээс гэр бүлээрээ хамт хийсэн бөгөөд өөрсдийг нь хүчирхэгжүүлсэн үйл ажил-

лагаануудыг зурахыг хүс. Зурсан зургаа гэрийнхэнтэйгээ хуваалцахад нь тэднийг урамшуулан дэмж.



Гуравдахь долоо хоног: Санваар гэр бүлийг маань адисалж, хүчирхэгжүүлж чадна.

Сургаалыг таньж мэд

(тааварт тоглоом тогло): Та тэдэнд гэр бүлүүдийг адисалж, хүчирхэгжүүлдэг ямар нэгэн зүйлийн талаар санаа өгнө гэж хүүхдүүдэд хэл. Хариултыг мэдсэн үедээ гараа өргөхийг тэднээс хүс. “Энэ зүйлтэй эцгүүд гэр бүлээ адисалж чадна”, “12 настай хөвгүүд үүнийг авч болно” зэрэг санваарын талаар зарим санааг өг. Хүүхдүүдийг зөв таасны дараа тэдэнтэй хамт “санваар гэр бүлийг маань адисалж, хүчирхэгжүүлж чадна” гэж хэл.



Ойлголтыг урамшуулан

дэмж (санваарын тухай ярилцах нь): Хүүхдүүдээс санваартан хүмүүсийн хийж чаддаг зарим зүйлийг нэрлэхийг хүс (жишээлбэл, баптисм хүртээх, Ариун Сүнсний бэлэг өгөх, өвчтөнийг адислах,

ариун ёслолыг түгээх). Тэдэнтэй ярилцах зуураа тэдгээр ёслолууд болон адислалуудын зургийг үзүүлж, хүүхдүүдэд эдгээр нь хэрхэн гэр бүлүүдийг адисалж, хүчирхэгжүүлдгийг ойлгоход нь тусал. Ариун сүмийн зураг үзүүл. Санваарын хамгийн агуу адислалуудын нэг нь ариун сүм орж, гэр бүлээрээ мөнхөд хамтдаа холбогдох гэдгийг тайлбарла.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж

(санаагаа хуваалцах нь): Хэсэг хүүхдүүдээс босч зогсоод санваар тэдний гэр бүлийг адисалж, хүчирхэгжүүлсэн нэг эсвэл хоёр арга замыг хуваалцахыг хүс. Гэртээ гэр бүлийнхэнтэйгээ мөн хуваалцахыг урамшуулан дэмж.

Дөрөвдэх долоо хоног: Тэнгэрлэг Эцэг намайг ариун сүмд гэрлэж, мөнхийн гэр бүлтэй болоосой гэж хүсдэг.

Сургаалыг таньж мэд (зураг үзэх нь): Хуримын хувцастайгаа ариун сүмийн өмнө зогсож байгаа хосын зургийг үзүүл. Хүүхдүүдээс Тэнгэрлэг Эцэг яагаад биднийг ариун сүмд гэрлээсэй гэж хүсдэгийг асуу. Биднийг ариун сүмд гэрлэсэн үед бидний гэр бүл мөнхөд хамтдаа байж чадна гэдгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж

(гэрчлэл сонсох нь): Хэсэг багш нарыг гэрлэсэн хосын хамт урьж, ариун сүм болон ариун сүмийн гэрлэлтээс ирсэн адислалуудынхаа талаар хуваалцахыг хүс. Тэднийг санал бодлоо хуваалцах зуур хүүхдүүдээс тодорхой адислалуудыг олж сонсохыг хүс. Тэдгээр адислалуудыг самбар дээр жагсаа.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг

урамшуулан дэмж: Цөөхөн хэдэн хүүхдээс босч зогсоод яагаад ариун сүмд гэрлэхийг хүсч байгаагаа мөн энэхүү адислалд бэлтгэхийн тулд одоо юу хийж чадахаа хуваалцахыг хүс.



Санамж: Мөнхийн

гэр бүлийн тухай зааж байхдаа эцэг эхгүй өнчин хүүхдүүдэд болгоомжтой мэдрэмжтэй хандаарай. Мөн Сүмийн гишүүн бус эсвэл эцэг эх, ахан дүүс нь сүмд идэвхгүй болсон хүүхдүүдэд мэдрэмжтэй хандаарай. Бүх хүүхдүүдийг нэгэн өдөр өөрсдийн мөнхийн гэр бүлүүдтэй болохоор зохистой амьдрахыг урамшуулан дэмж.

Тэнгэрлэг Эцэг миний залбирлыг сонсож, хариулдаг.

Дуулал: “Хүүхдийн залбирал”
(ХДН, 12–13)

Хүндэтгэл бишрэл:

Хүүхдүүд үйл хөдлөл, үйл ажиллагаагаар дамжуулан суралцдаг. Хүүхдүүдээ дараагийн үйл ажиллагаанд бэлтгэхийн тулд хөдөлгөөнт хөтөлбөрөө хүндэтгэлтэйгээр дуусгах хэрэгтэй. Хүндэтгэл бишрэлийн дууг дуул.

Хүүхдүүд өөрсдөө үр дүнтэй, сайн оролцуулж болох үзүүлэх материалууд билээ. Энэ үйл ажиллагааны үеэр хүүхдүүд залбирах зөв арга замыг харуулах боломжтой болдог.

“Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно.” (С ба Г 112:10).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “**Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?**” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Судрууд хэрхэн залбирахыг надад заадаг.



Сургаалыг таньж мэд: Судруудыг барьж, хүүхдүүдээс судруудаас сурсан зарим зүйлсээ хуваалцахыг хүс. Судраас суралцах нэг зүйл бол хэрхэн залбирах гэдгийг хүүхдүүдэд хэл.

Ойлголт, хэрэгжүүлэлтийг урамшуулан дэмж (судрын түүхийг сонсох нь): Зорамчуудад зааж буй Алма, Амюлек хоёрын түүхийг ярьж өг (Алма 31; 33–34-г үз). Залбирах зөв арга замыг үг хэлэлгүйгээр үйлдлээрээ үзүүлэхийг хүүхдүүдээс хүс. Түүх залбирлын талаар юу зааж байгааг хүүхдүүдээс асуу. Хүүхдүүдийн хариултыг самбар дээр жагсаа. Түүх нь тэдэнтэй хэрхэн холбогдож байгааг ярилцахыг хүүхдүүдээс хүс.

Хоёрдахь долоо хоног: Тэнгэрлэг Эцэг намайг хаана ч байсан, ямар ч үед ойр ойрхон Өөрт нь хандан залбирахыг хүсдэг.

Сургаалыг таньж мэд, ойлголтыг урамшуулан дэмж (судар унших нь): Тэд Тэнгэрлэг Эцэгт хандан ямар ч үед, хаана ч гэсэн залбирч болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэднээс Алма 33:3–9-р шүлгийг олохыг хүс. Шүлгүүдийг хамтдаа уншаад хүүхдүүдээс Зиносын залбирсан газрыг сонсох бүртээ гараа өргөхийг хүс. Тэдгээр газруудыг самбар дээр бич. Тэдгээр газруудын орчин үеийн хувилбарыг цаасан дээр бичиж, эдгээр газрууд нь өнөөдөр тэдний хувьд ямар газар болохыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал

(жишээлбэл, ганцаараа байх газар нь “аглаг буйд”; цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, парк нь “талбай”; бидний анги, сүм дээрх цуглаан нь “цугласан олон” байж болно). Хүүхдүүдээс цаасан дээр бичсэн газруудыг самбар дээрх газартай тааруулахыг хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (залбирлын талаар ярилцах нь): Хүүхдүүдийг бүлэг болгон хувааж, тэднээс Зиносын залбирсан газруудад залбирсан туршлагаа хуваалцахыг хүс.

Гуравдахь, дөрөвдэх долоо хоног: Залбирлын хариултууд Тэнгэрлэг Эцэгээс маш олон арга замаар ирдэг.

Сургаалыг таньж мэд (тоглоом тоглох нь): Хүүхдийн хэсгийн хичээлийн өмнө самбар дээр “Залбирлын хариултууд Тэнгэрлэг Эцэгээс маш олон арга замаар ирдэг” гэж бичээд үг тус бүрийг өөр өөр цаасаар бүтээ. Нэг хүүхдээс нэг цаасыг авч, бусад хүүхдүүдээс өгүүлбэрийг таахыг хүс. Хүүхдүүд өгүүлбэрийг таах хүртэл цаасыг авч, өгүүлбэрийг хамтдаа уншихыг тэднээс хүс.

Ойлголтыг урамшуулан дэмж (судар унших нь): Иосеф Смит аль сүмд нэгдэх ёстойгоо мэдэхийн тулд залбирсан гэдгийг хүүхдүүдэд хэл. Түүний залбирал хэрхэн хариулагдсаныг олж мэдэхийн тулд Иосеф Смит—Түүх 1:17-г хамтдаа унш (Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн айлчлалаар дамжуулан). Алма өөрийн хүү бага Алмаг үнэнийг суралцаасай хэмээн залбирсныг хүүхдүүдэд хэл. Алмагийн залбирал хэрхэн хариулагдсаныг олж мэдэхийн тулд Мозая 27:11-г



хамтдаа унш (тэнгэр элч бага Алмад үзэгдсэн). Залбирлын ихэнх хариултууд өөр арга замаар ирдэг гэдгийг тайлбарла. Өөр өөр цаасан дээр залбирлын хариултууд ирж болох арга замыг харуулсан дараах судруудыг бич: С ба Г 6:22–23 (амар амгалан мэдрэмжээр); С ба Г 8:2 (оюун санаан дахь бодол, зүрх сэтгэл дэх мэдрэмжээр); Мозая 27:36 (бусад хүмүүсийн үйлдлээр); 2 Нифай 32:3 (судруудаар). Цааснуудыг хайрцганд хий. Нэг хүүхдээс цаасыг сугалж авч, уншихыг хүс. Судрын эшлэлийг олоод, хамтдаа унш. Мөн хүүхдүүдээс эдгээр судар бүр Тэнгэрлэг Эцэг залбиралд хэрхэн хариулдаг талаар юу зааж байгааг асуу.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (түүхүүд сонсох нь):

Дөрвөн зочныг ангид урьж, залбирлын хариулт ирдэг арга замыг харуулсан түүх хуваалцахыг хүс. Түүх нь магадгүй хувийн туршлага, Сүмийн сэтгүүл эсвэл судраас байж болно. Хүүхдүүдийг гэртээ хариад гэрийнхнээсээ тэдний залбиралд хариулт ирсэн үеүдийн талаар асуухыг урь.



Долоо хоног бүр хүүхдүүдийн суралцах сургаалыг тодорхой танилцуул. Тэднийг тантай хамт тэдгээрийг хуваалцах цагийн эхэнд давтан хэлэхийг урь.

Хөгжмийн удирдагчдад зориулсан тусламж

Хүүхдүүдэд туслахын туд “Хүүхдийн залбирал” (ХДН, 12–13) дууллыг суралцаж, дараах зүйлийг анхаар:

- Хүүхдүүдээс гэр бүлээсээ урт хугацаанд хол байсны дараа гэртээ эргэж ирээд хаалгаа онгойлгоод хайр, тайтгарлаар дүүрч байна гэж төсөөлөхийг хүс. Залбирал нь Тэнгэрлэг Эцэгт хүрэх хаалгыг нээхтэй адил; Тэр биднийг тайтгаруулж, хайрлахаар хүлээж байдаг бөгөөд хүүхэд бүрийн залбирлыг сонсож, хариулахыг хүсдэг гэдгийг тайлбарла.
- Таныг “Хүүхдийн залбирал” дууллын эхний хоёр мөрийг дуулах үед “тэнд”, “залбирал” гэдэг үгсийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Үгсийг сонсох бүртээ чихэндээ хүрээ-

хийг хүүхдүүдээс хүс. Тэдгээр мөрүүдийг тантай хамт дуулахыг хүс. Энэ мэтээр дууллын үлдсэн мөрүүдийг давтаж, хүүхдүүдээс мөр бүр дэх толгой холбосон үгсийг олж сонсохыг хүс.

- Хоёрдахь бадгийн өгүүлбэр бүрийг дуулж, таныг өгүүлбэр рүү заах үед өгүүлбэрийг давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс. Хүүхдүүдийг хоёр бүлэгт хувааж, нэг бүлгээс нь өгүүлбэр бүрийн эхний хэсгийг дуулахыг (жишээлбэл, “Тэр”) харин нөгөө бүлгээс өгүүлбэрийг (“байдаг”) дуусгаж дуулахыг хүс. Хүүхэд бүрийг босч зогсоод “хаант улс, хаант улс тэднийх юм” дуулахыг хүс.

Судрууд: Сайн мэдээний үнэнийг судруудаас суралцах нь хүүхдүүдийн хувьд маш чухал билээ. Судруудаас заахдаа судруудыг гартаа барь.



Би Бурханд бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа үйлчлэх болно.

“Чи Их Эзэн Бурханаа бүх зүрх сэтгэлээрээ, өөрийн бүх хүчин чадал, оюун хийгээд чадлаараа хайрлах ёстой; мөн Есүс Христийн нэрээр чи түүнд үйлчлэх ёстой.”
(С ба Г 59:5).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**


Жүжигчлэн заах:

Жүжигчлэн заах эсвэл жүжиглэх нь хүүхдүүдэд сайн мэдээний зарчмуудыг бодит амьдралын нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд тусалдаг. Энэ нь мөн хүүхдүүдэд хичээлд идэвхтэй оролцох боломжийг өгдөг.

Нэгдэх долоо хоног: Есүс Христ бидэнд бусдад хэрхэн үйлчлэхийг заасан.

Сургаалыг таньж мэд (зурагуу харах нь):

Бусдад үйлчилж буй Есүс Христийн хэдэн зургийг харуул. Жишээлбэл, СМЗН-ын 41, 42, 46, 47, 55-р зурагнуудыг ашигла. Зураг бүр дээр юу болж байгааг тодорхойлохыг хүүхдүүдээс хүс. Зураг бүр дээр Есүс Христ бусдад үйлчилж байгаа гэдгийг онцол. Самбар дээр “Есүс Христ бидэнд бусдад хэрхэн үйлчлэхийг заасан” гэж бич.



Ойлголтыг урамшуулан дэмж (судар судлах, жүжигчлэн заах): Хүүхдүүдээс Матай 25:35–36 дээр гарсан хэрэгцээг ээлжлэн жүжигчилж үзүүлэхийг хүс. Жишээлбэл, хүүхэд өлссөн, цангасан, өвчтэй эсвэл харь хүнийг жүжигчлэн үзүүлж болно. Өөр нэг хүүхдээс хэрэгцээг тааж, ийм тусламж хэрэгтэй хүнд хэрхэн туслахыг жүжигчилж үзүүлэхийг хүс. Матай 25:35–40-г хамтдаа уншиж, хүүхдүүдээс бид бусдад үйлчилсэн үедээ хэнд үйлчилж байгаа гэж Есүс Христ хэлснийг олж сонсохыг хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж: Хүүхдүүдэд цаас өгч, тэднээс үйлчилж болох хүмүүсийнхээ нэрийг жагсааж бичих эсвэл зургийг нь зурж, тэдгээр хүмүүст хэрхэн тусалж болохоо зурахыг хүс. Гэртээ гэр бүлийнхэнтэйгээ мөн хуваалцахыг урамшуулан дэмж.

Хоёрдахь долоо хоног: Бошиглогчид болон төлөөлөгчид бидэнд хэрхэн үйлчлэхийг харуулсан.

Сургаалыг таньж мэд: Мосе, Хаан Бенжамин, Иосеф Смит болон Томас С.Монсонгийн зургийг үзүүл. Эдгээр бошиглогч нь бусад бошиглогч, төлөөлөгчдийн адил бидэнд хэрхэн үйлчлэхийг харуулсан гэж хүүхдүүдэд хэл.

логч, төлөөлөгчдийн адил бидэнд хэрхэн үйлчлэхийг харуулсан гэж хүүхдүүдэд хэл.

Ойлголтыг урамшуулан дэмж (тааварт тоглоом тоглох нь): Мосе, Хаан Бенжамин, Иосеф

Смит, Томас С.Монсон бидэнд хэрхэн үйлчлэхийг хэрхэн харуулсан тухай санааг бэлтгэ. Жишээлбэл, Ерөнхийлөгч Монсонгийн тухай зарим санаа нь “Би тойргийнхоо бэлэвсэн эгч нарт ойр ойрхон зочилдог”, “Би бяцхан хөвгүүн байхдаа өөр нэг хүүхдэд өөрийнхөө дуртай тоглоомыг өгсөн”, “Би эмнэлэгт байгаа хүмүүст ойр ойрхон зочилдог” байж болно. Та магадгүй санааг бэлтгэхийн тулд дараах судрын эшлэлүүдийг ашиглаж болно. Мосе: Египетээс гарсан нь 2:16–17; 1 Нифай 17:24–29. Хаан Бенжамин: Мозая 2:12–19. Иосеф Смит: Иосеф Смит—Түүх 1:62, 67; С ба Г 135:3. Томас С.Монсон: *Ensign*, 1994 оны 9-р сар, 12–17; 1995 оны 12-р сар, 2–4; 2006 оны 11-р сар, 56–59.

Нөмрөг, бүрх малгай зэрэг энгийн хувцас нь жүжигчилсэн тоглолтыг илүү сонирхолтой болгоно. Жүжигчилсэн тоглолт нь сайн мэдээний зарчмуудын талаар болон судруудын түүхийг илүү сайн ойлгоход хүүхдүүдэд тусална.



Тэдгээр бошиглогчдыг төлөөлөх дөрвөн хүүхдийг сонгож, таны бэлтгэсэн санааг уншихыг нэг хүүхдээс хүс. Тэр бошиглогч хэн болохыг таасан үедээ гараа өргөн хэлэхийг хүс. Тэгээд бошиглогчийн зургийг олохыг тэднээс хүс. Үлдсэн гурван бошиглогч дээр мөн адил хий.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (чуулганыг сонсох нь):

Ирэх сард хүүхдүүдийг ерөнхий чуулганыг үзэж эсвэл сонсохыг урь. Бусдад хэрхэн үйлчлэх талаар түүхүүдийг сонсохыг урамшуулан дэмж. Сурсан зүйлсээ хуваалцах боломжийг тэдэнд олго.

Гуравдахь, дөрөвдэх долоо хоног: Би бусдад үйлчилснээр Бурханд үйлчилдэг.



Сургаалыг таньж мэд (судар цээжлэх нь):

“Та нар бусдаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа” гэж самбар дээр бичин хүүхдүүдэд Мозая 2:17-г цээжлэхэд нь тусал. Хүүхдүүдийг өгүүлбэрийг хоёр эсвэл гурван удаа давтаж уншихыг урь. Нэг хүүхдээс өгүүлбэрийн нэг эсвэл хоёр үгийг нь арилгахыг хүссэний дараа хүүхдүүдээр уншуул. Ямар ч үг үлдэхгүй болтол үргэлжлүүл.

Ойлголтыг урамшуулан дэмж (жишээг сонсох нь): Хичээлийг бэлтгэхдээ 2010 оны 4-р сарын ерөнхий чуулган дээр Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф ахын өгсөн “You Are My Hands” (Ensign эсвэл Лиахона, 2010 оны 5-р сар, 68–70, 75-г үз) яриаг залбиралтайгаар судал. Бид эргэн тойрондоо байгаа хүмүүст үйлчилснээр хэрхэн Бурханд үйлчилдэг тухай хүүхдүүдээс асуу (Хэрвээ тэр энд байсан бол хийх байсан зүйлүүдийг бид хийдэг). Үйлчлэлийн тухай түүх эсвэл хувийн туршлагаа хуваалцаж, энэ нь өгч байгаа болон авч байгаа хоёуланг нь хэрхэн адисалдгийг тайлбарла. (Та нар үйлчлэлийн талаарх түүхүүдийг Friend эсвэл Liahona-гаас харж болно.) Зарим жишээг бэлтгэ (TNGC, 161–62-г үз) энэ нь хүүхдүүд хэрхэн бусдад үйлчилдгийг харуулдаг. Жишээлбэл: “Анни сургуулиасаа гэртээ харьж яваад халтираад унажээ. Түүний ном, дэвтэрүүд нь газраар нэг тарсан байлаа. Дэвид түүнд тусалж,

номнуудыг нь авч өгөхөөр зогсов.” “Мэригийн хөрш хүүхэд нь уйлах зуур худалдаж авсан хоол хүнсээ гэр рүүгээ оруулах гэж хичээж байна. Мэри хоол хүнсээ гэртээ оруулахад нь түүнд тусалжээ.” Хүүхдүүдээс жишээ хичээлүүдийг жүжигчилж үзүүлэхийг хүсч, хэнд үйлчилснийг нь асуу (тусалсан хүндээ болон Бурханд).

Ойлголт, хэрэгжүүлэлтийг урамшуулан дэмж (тохируулах тоглоомыг тогло): Эцэг эх, ах дүү нар, эмээ өвөө, найз, хөрш зэрэг хүүхдүүдийн үйлчилж болох хүмүүсийн зургийг зур эсвэл ол. Тэдгээр зурагнуудыг хувилаад, тэдэнтэй хамт тохируулах тоглоом тогло (TNGC, 169-г үз). Хүүхдүүд зургийг эвлүүлсэн үед тэднээс зурган дээрх хүнд үйлчилж болох нэг арга замыг хэлэхийг хүс. Хүүхдүүдийн санаануудыг самбар дээр жагсаан бич. Хэрхэн үйлчлэх талаар зарим санаануудыг Хүүхдийн хэсэг 4, 166-аас үз.

Өөр зүйлсийн тухай биш сайн мэдээний үнэнүүдийн тухай зааснаар сургаалыг цэвэр ариун хэвээр нь хадгал. Сүмийн хэвлэж гаргасан, зөвшөөрсөн хичээлийн материалуудыг үргэлж ашигла (TNGC, 52-г үз).



Тоглоом нь хичээлийг олон хэлбэртэй болгохын сацуу хүүхдүүдэд хамтран ажиллах, сайн мэдээний зарчмыг хөгжилтэй арга хэлбэрээр сурах боломж олгодог.

Би Бурханы бүх хүүхдүүдтэй сайн мэдээг хуваалцана

“Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, Тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” (Матай 5:16).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Сайн мэдээний дагуу амьдрах нь надад яг одоо номлогч болоход тусална.

Сургаалыг таньж мэд, ойлголтыг урамшуулан дэмж (түүх сонсох нь): Номлогчдын зургийг үзүүл. Номлогчид юу хийдгийг хүүхдүүдээс асуу. Дараах түүхийг хуваалц эсвэл *Friend* эсвэл *Лиахонагаас нэг түүх хуваалц*: “Нэгэн өдөр хоёр номлогч нэг айлын хаалгыг тогшжээ. Хатагтай Жеймс хаалгыг онгойлгожээ. Номлогчид түүнд өөрсдийгөө Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс явж байгаа гэдгээ хэлжээ. Хатагтай Жеймс номлогч нарыг гэртээ оруулж, Сүмийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байгаагаа хэлжээ. . . . Хатагтай Жеймс номлогч нарт Сүмийн гишүүн гэр бүлтэй хөрш байснаа хэлжээ. Тэр тухайн гэр бүл дэх хүүх-

дүүд үргэлж эелдэг байдаг байсан бөгөөд хүн бүртэй ялгаварлалгүй тоглож, бусад хүмүүсийн эд хогшилд хүндэтгэлтэй ханддаг байсан гэж хэлжээ. Хатагтай Жеймс тэдгээр хүүхдүүдэд тийм сайхан зан авиртай болохыг заасан сүмийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байгаагаа хэлжээ” (*Хүүхдийн хэсэг 2*, 52). “Хатагтай Жеймсийн хөрш хүүхдүүд нь ямар хүүхдүүд байсан бэ” гэж асуу. Бид сайн мэдээний дагуу амьдрах бүртээ номлогч болдог гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг тантай хамт “Сайн мэдээний дагуу амьдрах нь надад яг одоо номлогч болоход тусална” гэж хэлэхийг урьж, яг одоо гэдэг үгийг онцол.

Бататгах: Ерөнхий чуулганаас сурсан зүйлсээ хуваалцах боломжийг хүүхдүүдэд олгохоо битгий мартаарай (Есдүгээр сар, хоёрдахь долоо хоног-г үз).

Хоёрдахь долоо хоног: Сайн мэдээний дагуу амьдрах нь надад яг одоо номлогч болоход тусална.



Сургаалын тухай дуулах нь түүнээс суралцаж, санаж байхад нь хүүхдүүдэд тусалдаг. Мөн хүүхдүүд үзүүлэнт эсвэл хөгжимт үйл ажиллагаа хийх үед илүү сайн суралцдаг.

Ойлголтыг урамшуулан дэмж (дуулал дуулж, сайн мэдээний жишгүүдийн талаар ярилц): “Миний сайн мэдээний жишгүүд” номны жишиг бүрийг бичсэн 13 карт бэлтгэ (“Хуваалцах цаг: Зарлигуудыг дагацгаая”, *Friend*, 2006 оны 6-р сар, 36-г үз). Зарим картуудыг хүүхдүүдэд өгч, хүн бүр “I Want to Be a Missionary Now” (*ХДН*, 168) дууллыг дуулах зуур картаа бусад хүүхдүүд рүү дамжуулахыг хүс. Дуулж дууссаны дараа карт барьж байгаа хүүхэд бүрийг картан дээрх жишгээ чангаар уншиж, энэ жишгийн дагуу амьдрах нь түүнд яг одоо номлогч болоход нь хэрхэн туслах талаар хуваалцахыг хүс. Өөр картуудыг ашиглаж давт.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (зорилго тавих нь):

Хүүхэд нэг бүрээс ирэх долоо хоногт илүү сайн дагах сайн мэдээний жишгийг сонгохыг хүс. Тэднийг сонгосон жишгээ цаасан дээр зурж эсвэл бичиж, өдөр бүр сануулга болгон харахыг дэмж. Тэднийг дараагийн долоо хоногт Хүүхдийн хэсэг дээр туршлагаа хуваалцахыг урь.

Гуравдахь долоо хоног: Би сайн мэдээг гэр бүл, найз нөхөдтэйгөө хуваалцаж чадна.

Сургаалыг таньж мэд (түүх сонсох нь): Хүүхдийн хэсгийн хичээлийн өмнө 2000 оны ерөнхий чуулганаар Ахлагч Роберт С.Өүкс ахын өгсөн “Sharing the Gospel” (Ensign, 2000 оны 11-р сар, 81–82-г үз) яриаг унш. Хүүхдүүдэд жүржийн шүүсний талаарх түүхийг ярьж өг. Сайн мэдээ бол жүржийн шүүснээс илүү амттай бөгөөд үүнийг бид бусадтай хуваалцах ёстой гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээр “Би сайн мэдээг гэр бүл, найз нөхөдтэйгөө хуваалцаж чадна” гэж хэлүүл.

Ойлголтыг урамшуулан дэмж (зочин яриа өгөгчийг сонсох): Хүүхдүүд бусадтай сайн мэдээг хуваалцаж болох арга замуудын тухай (жишээлбэл, сайн үлгэр жишээ үзүүлж, найзуудаа Хүүхдийн хэсэгт урьж, гэрчлэлээ хуваалцах) мөн сайн мэдээг хуваалцах тэдний хичээл зүтгэл

Тэнгэрлэг Эцэг болон номлогч нарт хэрхэн тусалдаг тухай ярихыг номлогч эсвэл буцаж ирсэн номлогчоос хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (Түүх сонсож, санаагаа хуваалцах нь): Хүүхдүүдэд тэд яг одоо номлогч болж чадна гэдгийг сануул. Та эсвэл таны таньдаг хэн нэгэн сайн мэдээг хуваалцаж байсан үеийг хуваалц. Хүүхдүүдээс нэг нэгээрээ босч, “Би сайн мэдээг хуваалцаж чадна” гэх өгүүлдэрийн үгийг нэг нэгээр нь хэлэхийг хүс. “Сайн мэдээ” гэж хэлсэн хүүхдээс сайн мэдээг гэр бүл, найз нөхөдтэйгөө хуваалцаж болох арга замын тухай бодохыг хүс. Цаг байвал үргэлжлүүлэн хий.

Зөвлөгөө: Зарим долоо хоног зөвхөн нэг удаагийн хуваалцах цагаар багтаах боломжгүй олон санаануудыг агуулдаг. Танай Хүүхдийн хэсэгт хамгийн сайн тохирох үйл ажиллагааг залбиралтайгаар сонго.

Дөрөвдэх долоо хоног: Би сайн мэдээг хуваалцах үед миний гэрчлэл хүчирхэгждэг.

Сургаалыг таньж мэд (үзүүлэнт хичээлийг үзэх нь): Цэвэрхэн шилийг усаар дүүргэ. Биднийг сайн мэдээг хуваалцах бүрт бидний гэрчлэл хүчтэй болдог гэдгийг тайлбарла. Шилэн дотор будаг оруулагч дусаа. Жишээ бүр дээр адил өнгийн будаг оруулагчийг усан дээр дусааж, сайн мэдээг хэрхэн хуваалцах хэдэн жишээг өг. Будаг оруулагчийг дусаах бүрд усны өнгө нь тодорч байгаагийн адил биднийг сайн мэдээг хуваалцах бүрд бидний гэрчлэл хүчирхэг болдог гэдгийг онцолж тайлбарла.



Үзүүлэнт хичээл нь хичээлийг сонирхолтой болгож, хүүхдийн анхаарлыг сайн мэдээний зарчмуудад төвлөрүүлдэг.

Ойлголтыг урамшуулан дэмж (гэрчлэлийн тухай ярилцах нь): Дараах зүйлийг сагсанд хий: Есүс Христийн зураг, Иосеф Смитийн зураг, одоогийн бошиглогчийн зураг, Мормоны Ном, “Үнэн Сүм” гэж бичсэн цаас. Самбар дээр гэрчлэл гэж бичээд хүүхдүүдээс гэрчлэл гэж юу болохыг асуу. Тэдний хариултуудыг ярилц. Дараах



түүхийг ярьж өг: “Бяцхан охин өөрийнхөө мэдрэмжинд итгэлтэй биш байсан учраас гэрчлэлээ хуваалцахаас айжээ. Гэсэн ч тэр гэрчлэлээ хуваалцах нь чухал гэдгийг мэдэж байсан бөгөөд нэг өдөр зоригтойгоор босч зогсоод гэрчлэлээ хуваалцаж, итгэдэг таван зүйлээ гэрчилжээ. Тэр дууссаныхаа дараа сайхан мэдрэмжийг мэдэрч, түүний гэрчлэл хүчирхэг болсныг мэджээ.” Сагсанд байгаа зүйлсийг гаргах бүртээ уг охины гэрчилсэн таван зүйлийг хэлэхийг хүүхдүүдээс хүс. Сагснаас гаргасан зүйл бүрийн тухай ярилцаж, тэдгээрийг самбарын өмнө тавь.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (жишээ хуваалцах нь): Хэрхэн сайн мэдээг хуваалцаж болох жишээг хуваалцах боломжийг хүүхэд нэг бүрт олго. Хүүхэд ямар нэгэн зүйл хэлэх бүрт сайн мэдээг хуваалцах нь гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг гэдгийг харуулахын тулд будаг оруулагчийг усанд дусаа. (Хэрэв танайд томоохон Хүүхдийн хэсэг байдаг бол хүүхдүүдийг бүлэг болгон хувааж болох ба ингэснээр хүүхэд бүр хичээлд оролцох боломжтой болно.)

Хариултуудыг урь:

Сургаалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар хуваалцах нь хүүхдүүдийн зүрх сэтгэлд сургаалыг бататгаж, Сүнсийг урьдаг. Сургаал заасныхаа дараагаар үүнийг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлэх талаар хүүхдүүдэд сэтгэгдлээ хуваалцах боломжийг олго.

Бид бүх зүйлд Бурханд талархалтай байх ёстой

“Өдөр бүр тэд Их Эзэн Бурхандаа талархлаа илэрхийлэх ёстойг тэрээр тэдэнд зарлиг болгов” (Мозая 18:23).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Хүүхдийн хэсгийн

дуунууд нь хүүхдүүдэд сургаалыг санахад тусалдаг. Заасан зүйлийг тань бататгах дуулыг сонгож дуулахад анхаар. Энэ сард тэдгээр дуунуудын зарим нь “Children All Over the World” (ХДН, 16–17), “For Health and Strength” (ХДН, 21), “I Think the World Is Glorious” (ХДН, 230), “Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг” (ХДН, 228–29), “Thanks to Our Father” (ХДН, 20) байж болно.

Нэгдэх долоо хоног: Би бие махбодтой байгаадаа талархдаг. Энэ бол ариун сүм гэдгийг би мэднэ.

Сургаалыг таньж мэд (зураг үзэж, судар унших нь): Хүүхэд болон ариун сүмийн зургийг үзүүл. 1 Коринт 3:16-г хамтдаа чанга унш. “Бид өөрсдийнхөө бие махбодын талаар судраас юу сурдаг вэ” гэж асуу. “Миний бие бол ариун сүм” гэж самбар дээр бич.

Ойлголтыг урамшуулан дэмж (судар судлах нь): Бид бие махбодтой байгаадаа талархалтай байгаагаа Тэнгэрлэг Эцэгт харуулах арга замуудыг ярилц; жишээлбэл, бид бие махбодоо халамжилж, цэвэр ариун байлгадаг. Бошиглогчид бидэнд тамхи татахгүй, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэхгүй, шивээс

хийлгэхгүй байснаараа бие махбодоо халамжлахыг зөвлөсөн. Хүүхдүүдийг бүлэг болгон хувааж, бүлэг бүрээс дараах судруудын нэгийг эсвэл үүнээс илүүг уншиж, ярилцахыг хүс: Сургаал ба Гэрээ 88:124; 89:7, 8, 9, 10–11, 12, 16–17. Бие махбодоо халамжлах талаар эдгээр судраас юу сурснаа хуваалцахыг бүлэг бүрээс хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (зорилго тавих нь):

Хүүхдүүдээр долоо хоногийн турш бие махбодоо халамжлахын тулд хийх ямар нэгэн зүйлийг зурж эсвэл бичүүл.

Хоёрдахь долоо хоног: Би түр зуурын адислалуудад талархалтай байдаг.

Сургаалыг таньж мэд: “Би түр зуурын адислалуудад талархалтай байдаг” гэж бич. Хүүхдүүдээс өгүүлбэрийг хэлэхийг хүс. Түр зуурын адислалууд гэдэг нь харж, барьж, сонсож, амталж, үнэрлэж болдог адислалууд гэдгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (тааварт тоглоом тоглох нь): Түр зуурын адислалуудын талаарх зарим зураг эсвэл биетийг үзүүл (жишээлбэл, бие махбод, гэр орон, хоол хүнс, ус, хувцас, эрүүл мэнд, нар, сар, од, дэлхий, амьтан, ургамал, гэр бүл, найз нөхөд, тоглоом, ном, сургууль). Адислалуудын нэгийг нь тодорхойлох санааг өгч, хүүхдүүдээс ямар адислал гэдгийг нь асуу. Ахимаг насны хүүхдүүдэд зориулж өөр өөр цаасан дээр адислалуудыг бичиж, хайрцганд хий. Нэг хүүхдээс нэг цаасыг сонгож, бусад хүүхдүүдэд үүний талаар санаа өгөхийг хүс. Хүүхдүүд адислалыг таасны дараа самбар дээр бичиж, нэг хүүхдээс яагаад энэ адислалд талархалтай байдгийг нь асуу.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (санаа хуваалцах нь):

Ярилцсан адислалуудынхаа төлөө талархлаа илэрхийлэхийн тулд юу хийж болохыг тэднээс асуу. Өөрсдийн бодлыг хуваалцахыг хэдэн хүүхдээс хүс.

Олон төрлийн заах арга замыг ашиглах нь хүүхдүүдийг илүү үр дүнтэй суралцахад нь тусалдаг. Бүх хүүхдүүдийг оролцуулсан заах арга зам, үйл ажиллагааг сонго.



Гуравдахь долоо хоног: Би сүнслэг адислалуудад талархалтай байдаг.

Сургаалыг таньж мэд, ойлголтыг урамшуулан дэмж (*судар унших нь*): Аврагчийн зураг болон дараах судрын эшлэлийг дотор нь хийсэн бэлэг бэлтгэ: Моронай 10:8–17. “Би сүнслэг адислалуудад талархалтай байдаг” гэж самбар дээр бич. Их Эзэн бидэнд өгдөг маш олон сүнслэг адислалууд байдаг бөгөөд Тэрээр Ариун Сүнсний хүчээр бидэнд тэдгээр адислалуудыг өгдөг гэдгийг тайлбарла. Нэг хүүхдээр бэлгийг задлуулж, дотор нь байгаа зүйлийг харуул. Хүүхдүүдээс судрыг олж, Их Эзэн бидэнд өгч болох сүнслэг адислалуудыг тодорхойлохыг хүсч, тэдгээрийг самбар дээр бич. Зарим адислалуудын тухай ярилцаж, бид тэдгээрийг бусдад туслахын тулд ашиглах ёстой гэдгийг тайлбарла.



Дөрөвдэх долоо хоног: Бид бүх адислалуудынхаа төлөө Тэнгэрлэг Эцэгт талархах ёстой.

Сургаалыг таньж мэд: Хэн нэгэн танд өгсөн нэг юм уу хоёр зүйлийг хүүхдүүдэд үзүүл. Эдгээр бэлэг нь танд маш чухал гэдгийг мөн та тэдэнд “баярлалаа” гэж хэлснийг тайлбарла. Хүүхдүүдээс хүлээн авсан бэлгийнхээ төлөө талархал илэрхийлэх өөр арга замуудыг хуваалцахыг хүс. Хүүхдүүдээс өөрсдийн бүх адислалын төлөө хэнд талархал илэрхийлэх ёстойг асуу. Бүх адислалынхаа төлөө Тэнгэрлэг Эцэгт талархал илэрхийлэх ёстой шалтгаануудын талаар ярилц.

Ойлголтыг урамшуулан дэмж (*жагсаалт гаргах нь*): Таван өөр сагсанд цаас, харандаа, дараах зүйлсийн нэгийг нь хий: Сүмийн цуглааны байрын зураг, хувцаслалтын тухай тунхаг, судар, гэр бүлийн зураг, Аврагчийн зураг. Хүүхдүүдийг

бүлгүүдэд хувааж, бүлэг бүрт нэг сагсыг өг. Бүлэг бүрээс сагсанд байгаа зүйлийг харж, цаасан дээр үүний төлөө талархал илэрхийлэх нэг арга замын талаар бичихийг хүс. Дараа нь тэднээс цаас, харандаа зэрэг зүйлсээ сагсанд буцааж хийгээд өөр бүлэгт өгөхийг хүс. Бүлэг бүрт бүх сагс ээлжилж очтол үргэлжлүүлж, бүлэг бүрийг сагсанд байгаа жагсаалтан дээрх зүйлсийг хуваалцахыг хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*санааг хуваалцах нь*): Хэдэн хүүхдээс энэ үйл ажиллагаанаас сурсан зүйлсээ болон сурсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд юу хийхийг хуваалцахыг хүс.

Самбар: Самбар нь хамгийн энгийн, боломжтой заах хэрэгслүүдийн нэг мөн. Та хүүхдүүдийн хариултауд болон санаануудыг самбар дээр бичин танилцуулахад самбарыг ашиглаж болно.



Хүүхдүүдийг жижиг бүлгүүдэд хувааснаар илүү олон хүүхдэд оролцох боломж өгч байгаа юм. Багш нар хүүхдүүдийн оролцоо хийгээд хүндэтгэлтэй байдлыг хадгалахад нь тусална.

Арванхоёрдугаар сар: Би Есүс Христ дахин ирнэ гэдгийг мэднэ

“Миний Золигч амьд гэдгийг болон эцэст Тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ гэдгийг би мэднэ.” (Иов 19:25)

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Бошиглогчид Есүс Христ дэлхий дээр ирнэ гэдгийг угтан хэлсэн.

Ойлголтыг урамшуулан дэмж (судар унших нь): Сайн мэдээний зургийн ном болон Хүүхдийн хэсэг 4 зургийн багцаас Исаиа, Нифай, Хаан Бенжамин, Абинадай, Алма, лемен үндэстэн Самуелийн зургийг үзүүл. Хүүхдүүдийг бүлгүүдэд хувааж, бүлэг бүрт дараах судруудын нэгийг өг: (1) Исаиа 7:14; 9:6; (2) 1 Нифай 11:14–15, 20–21; (3) Мозая 3:5–8; (4) Мозая 15:1; (5) Алма 7:10–12; мөн (6) Хиламан 14:1–3. Хүүхдүүдээс хэн гэдэг бошиглогч ярьж байгааг мөн хэний тухай бошиглож байгааг асуу. Бүлэг бүрээс бошиглог-

чийн зургийг үзүүлж, бусад хүүхдүүдэд хэн болохыг мөн тэр юу гэж хэлснийг хэлэхийг хүс. (Бага насны хүүхдүүдийн хувьд, зургаан хүүхдийг зургаан бошиглогчтой адилхан хувцаслахад нь тусал. Бошиглогч бүрийн тухай болон тэд Есүс Христийн төрөлт, номлолын тухай юу гэж хэлснийг товч ярь.) Эдгээр бошиглогчид Есүс Христ дэлхийд ирнэ гэдгийг угтаж хэлснийг тайлбарла. “Samuel Tells of the Baby Jesus” (ХДН, 36) дууллыг дуул. Бошиглогчдын угтан хэлснээр Есүс Христ дэлхийд ирсэн гэдгийг гэрчил.

Хоёрдахь долоо хоног: Есүс Христ дэлхийд дахин ирнэ.

Сургаалыг таньж мэд: Хоёрдахь Ирэлтийн тухай зургийг үзүүл (СМЗН, дугаар, 6б). Есүс Христ анх дэлхийд Бетлехемд бяцхан хүүхэд болон төрсөн гэдгийг хүүхдүүдэд сануул. Тэрээр дэлхийд дахин ирнэ гэдгийг бид судраас суралцагийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (тохируулах тоглоом тоглох нь): Дараах судруудыг ашиглан тохируулах тоглоом бэлтгэ, судар бүрийг өөр өөр цаасан дээр бичиж, хоёр хэсэгт

хайчил: Матай 16:27; Матай 24:30, 36, 42; Үйлс 1:9–11; С ба Г 36:8; С ба Г 45:57–59; С ба Г 88:95–98. Цаас бүрийг самбар дээр доош харуулан тавь. Хүүхдүүдээс хоёр цаасыг сонгож, дээш харуулахыг хүс. Хоёр цаас хоорондоо тохирч байгаа эсэхийг шалга. Хэрэв тохирохгүй бол буцааж доош нь харуул. Хэрэв тохирч байвал судрыг хэвээр нь үлдээж, хүүхдүүдээс энэ нь Христийн ирэлтийн тухай юу зааж байгааг мэдэхийн тулд судрыг олохыг хүс. Бүх цаас тохиртол үргэлжлүүлэн хий.

Гуравдахь долоо хоног: Би Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй дахин хамт амьдрахын тулд бэлтгэнэ.

Сургаалыг таньж мэд (тааварт тоглоом тоглох нь): Хоёр эсвэл гурван хүүхдийг орондоо орж, сүм рүү явж, удаан хугацааны аялалд гарах гэж байгаа дүр эсгэхийг урь. Тэдний юу

Жүжигчлэн тоглох зэрэг тустай үйл ажиллагаануудыг сонирхолтой хичээл зааж, хичээлд анхаарлаа төвлөрүүлэхэд нь хүүхдүүдэд туслах зорилгоор ашиглаж болно. Хичээлд оролцохгүй байгаа хүүхдүүд бусад хүүхдүүдийн жүжигчилсэн тоглолтыг үзсэнээр хичээлд оролцож чадна.

Үйл ажиллагаануудыг өөрчил:

Үйл ажиллагаануудыг өөртөө байгаа эх сурвалж болон Хүүхдийн хэсгийнхээ хүүхдүүдэд тохируулан өөрчил. Жишээлбэл, гуравдахь долоо хоногийн хэрэгжүүлэлтийн үйл ажиллагаагаар та хүүхдүүдийг цаасан дээр санаагаа бичихийн оронд бэлтгэхийн тулд хийж чадах нэг зүйл бүрд нэг хуруугаа өргөхийг урьж болно.



хийж байгааг бусад хүүхдүүдээр таалга. Хэрэв бид тэдгээр зүйлсийг хийхийн тулд бэлтгэхгүй бол юу болох тухай хүүхдүүдтэй ярилц. Бидний бэлтгэх ёстой нэг чухал зүйл бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй дахин хамт амьдрах гэдгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (дуу дуулах нь): “Би Бурханы хүүхэд” (ХДН, 2) дууллын гуравдахь мөрийг дуулж, хүүхдүүдийг Тэнгэрлэг Эцэгтэй дахин хамт амьдрахын тулд бид хэрхэн бэлтгэж болохыг олж сонсохыг урь. Хүүхдүүдийг босч, зогсоод “Сургаалийг хэрэв дагавал” өгүүлбэрийг дахин дуулахыг урь. Зарим Хүүхдийн хэсгийн дуунууд нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй дахин хамт амьдрахын тулд бидний хийж болох зүйлсийн талаар сануулдаг гэдгийг тайлбарла (жишээлбэл, “Бурханы зааснаар амьдарна, би” [ХДН, 164–65], “Зарлигуудыг дагацгаая” [ХДН, 146–47], “Би элэгсэг нэгэн баймаар байна” [ХДН, 145], “Намайг баптисм хүртэхэд” [ХДН, 103]). Хөгжимчнөөс эдгээр дууллын аль нэгнээс нь хэдэн нот тоглож өгөхийг хүсч, хүүхдүүдээс ямар дуу болохыг нь таахыг хүс. Хүүхдүүдийг дууг дуулж, Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахын тулд бэлтгэж болох арга замуудын тухай дурдах бүрд босч зогсохыг урь. Энэ мэтээр бусад дуунууд дээр ажилла.

Ойлголтыг урамшуулан дэмж (зураг зурах нь): Хүүхдүүдээс Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй хамт амьдрахын

тулд тэдний бэлтгэж чадах арга замуудын тухай бодохыг хүс. Хүүхэд бүрд цаас өгч, гарынхаа хээг гаргаж зурахыг хүс. Тэгээд тэднээс зурсан гарынхаа хуруу бүр дээр бэлтгэхийн тулд хийх нэг зүйлийг бичихийг хүс. Хүүхдүүдээс бичсэн зүйлүүдээсээ нэгийг сонгож, ирэх долоо хоногийн турш хэрэгжүүлэхийг хүс. Дараагийн ням гарагт хийсэн зүйлсийг нь хуваалцуулна гэж хэл.

Сайн мэдээний зарчмуудыг **бичих нь** хүүхдүүдэд үүнийг санахад тусалдаг.



Дөрөвдэх долоо хоног: Би Бурханы хүүхэд хэмээх гэрчлэл надад бий.

Сургаалыг таньж мэд (таах тоглоом тогло): Самбар дээр “_____ надад бий” гэж бич. Хүүхдүүдээс дараах санааг сонсож, гараа цээжиндээ тэврээд хоосон зайг бөглөхийг хүсвэл босч зогсохыг хүс.

- Энэ нь бидэнд сайн сайхан, аз жаргал, халуун дулааныг мэдрүүлдэг.
- Ариун Сүнс бидэнд үүнийг өгдөг.
- Энэ нь бидэнд зөв сонголтуудыг хийх хүсэлтэй байхад тусалдаг.
- Бид Хүүхдийн хэсэг, гэр бүлийн үдэш, мацаг болон гэрчлэлийн цуглаанаар үг хэлэхдээ үүнийг бусадтай хуваалцаж болно.

“Энэ гайхамшигтай зүйл юу вэ?” гэж хүүхдүүдээс асуу. Хоосон зайг *гэрчлэл* гэдэг үгээр бөглөж, тэд өөрсдийгөө Бурханы хүүхэд гэсэн гэрчлэлтэй болж чадна гэдгийг хүүхдүүдэд хэл.

Ойлголтыг урамшуулан дэмж (дуу дуулах нь): Хүүхдүүдийг “Би Бурханы хүүхэд” (ХДН, 2–3) дууллыг дуулахыг урьж, тэднээс дуулах үедээ юу мэдэрснээ бодохыг хүс. Хэдэн хүүхдээс мэдэрсэн зүйлээ хуваалцахыг хүс. Тэдний мэдэрсэн сайхан мэдрэмж нь Ариун Сүнснээс ирсэн гэдгийг тайлбарлаж, тэд үнэхээр Бурханы хүүхдүүд гэдгийг тэдэнд хэл. Энэ нь үнэн гэдгийг мэдэх нь гэрчлэлтэй болох гэсэн үг гэдгийг тайлбарла. Бид Бурханы хүүхдүүд гэдгийг мэдэх маш олон арга зам байдгийг тайлбарла. “Та өөрийгөө Бурханы хүүхэд гэдгийг хэрхэн мэдсэн бэ?” гэж асуу.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (гэрчлэлийг сонсох нь): Хүүхдүүдээс “Бид бол Бурханы хүүхдүүд гэдэг гэрчлэлтэй байх нь яагаад чухал вэ? Гэрчлэлтэй байх нь бидэнд зөв сонголтуудыг хийхэд хэрхэн тусалдаг вэ?” гэж асуу. Өөрийнхөө гэрчлэлийг хуваалцаж, хэдэн хүүхэд болон насанд хүрэгсдийг бид бүгд Бурханы хүүхэд гэдэг гэрчлэлээ хуваалцахыг урь.

Гэрчил: Сүнсний нөлөөний дагуу зааж байгаа сургаалынхаа талаар гэрчлэлээ хуваалц; Ариун Сүнс таны хэлсэн зүйлийг үнэн гэдгийг хүүхэд бүрт гэрчилж чадна. Гэрчлэлээ хуваалцах нь хүүхдүүдэд Сүнсийг мэдрэхэд нь тусалж, тэднийг гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийг дэмждэг.



Хүүхдийн Хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай

Хүүхдийн Хэсэгт дуу хөгжим ашиглахын гол зорилго нь Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд заах явдал юм. Хүүхдийн хэсгийн дуунууд нь сайн мэдээг суралцах явцыг илүү хөгжилтэй болгож, Сүнсийг урьж, суралцахад нэн чухал хүндэтгэл бишрэлийн уур амьсгалыг бүрдүүлдэг. (Гарын авлага 2: Сүмийг удирдах нь [2010], 11.2.4-г үз).

Дуу заахаар бэлтгэхдээ өөрөөсөө “би хэрхэн хүүхдүүдийн анхаарлыг татаж, төвлөрүүлэх вэ? Энэ дуун дахь сайн мэдээний зарчмыг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд би ямар асуулт асуух вэ? Энэ дууг заахын тулд ямар арга хэрэглэх вэ?” гэж асуу. Таны ашиглаж болох зарим аргыг доор өгүүлэв. Жишээнүүд нь энэ хөтөлбөрт санал болгосон дуунууд дээр ажиллахад тань туслах болно. Нэмэлт санаануудыг авахын тулд LDS.org вэб сайтын Serving in the Church хэсгийн Хүүхдийн хэсэг мөн 2010, 2011, 2012 оны хуваалцах цагийн хөтөлбөрийн “Дуу хөгжмийг Хүүхдийн Хэсэгт хэрхэн ашиглах вэ” хэсгийг үз.

Үйл ажиллагааг

өөрчил: Энд дурдсан зарим заах санаанууд нь бага насны хүүхдүүдэд хамгийн тохиромжтой. Заах арга барилаа хүүхдүүдийн насанд тааруулж өөрчилж болох ба ингэснээр тэд бүгдээрээ суралцах, дуулах үйл ажиллагаанд оролцож чадна.

Дуун дахь сайн мэдээний зарчмуудыг онцол.

“Гэр бүл үүрд хамт байж болно” (ХДН, 188) дууллыг дуулахдаа дараах санааг авч үз. Дууллын эхний мөрийг дуулах хооронд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсгийг олж сонсоод энэ нь юу болохыг (гэр бүл) мэдсэн үедээ босч зогсохыг хүүхдүүдээс хүс. Энэ мөрийг тантай хамт дуулахыг хүүхдүүдээс хүс. Адил загварыг ашиглан “энд бий” мөн “намайг их хайрладаг” гэх өгүүлбэрийн нот руу зааж, хүүхдүүдээс тэдгээр үгсийг дуулахыг хүс. Тэд гэр бүлийнхэнтэйгээ хэр удаан хамт амьдрахыг олж мэдэхийн тулд дараагийн мөрийг сонсохыг тэднээс хүс. Хоёрдахь мөрийг дуулж, “үүрд мөнхөд” гэх үгийг онцол. Хүүхдүүдийг тантай хамт тэр мөрийг дуулж, дараа нь хоёр мөрийг хоёуланг нь дуулахыг урь. Мөн хүүхдүүдээс “хамт мөнхөд” гэдэг утгатай үгийг олж сонсохыг хүс. “Гэр бүл үүрд хамт байж болно” гэж дуулаад, хүүхдүүдээс давтаж дуулахыг хүс. “Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөснөөр” гэж дуулаад хүүхдүүдийг давтаж дуулахыг хүс. Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө юу болохыг



Хүүхдүүдэд дууны аяыг сурахад нь туслахын тулд “гараа шулуун байрлалд аваад үгсийг дуулж байх зуураа дээд нотыг дуулахдаа гараа өргөж, доод нотыг дуулахдаа гараа доошоо буулга” (TNGC, 174).

асууж, Тэрээр тэднийг ариун сүмд гэрлэж, өөрсдийн гэсэн мөнхийн гэр бүлтэй болоосой гэж хүсдгийг хүүхдүүдэд сануул. Өгүүлбэрүүдийг дуулж, хүүхдүүдийг дагаж дуулахыг уриснаар дууллыг төгсгө.

Дадлага хийх: Дууг үр дүнтэй сайн заахын тулд та өөрөө дуугаа сайн мэддэг байх ёстой. Та гэртээ дадлага хийснээр хүүхдүүдэд заахдаа тэдэн рүү харж чадна.

Хүүхдүүдэд дууны шүлгийг сурч, санахад нь туслахын тулд үзүүлэнтийн материалыг ашигла.

<p>Хэрэв Аврагч миний хажууд байсан бол</p>	<p>Би өөрийнхөө хийдэг зүйлсийг хийх байсан болов уу?</p>	<p>Би Түүний зарлигуудын тухай бодож,</p>	<p>үнэнч байхын тулд илүү их хичээх байсан болов уу?</p>	<p>Би Түүний үлгэр жишээг дагах байсан болов уу?</p>	<p>Хэрэв Аврагч миний хажууд зогсоод намайг харж байгааг</p>	<p>би харсан бол илүү зөв шударга амьдрах байсан болов уу?</p>

Зурагнуудыг харгахын тулд энд дарна уу.

“Хэрэв Аврагч миний хажууд байсан бол” дууллыг заахдаа дараах санаануудыг ашигла (энэхүү хуваалцах цагийн хөтөлбөрийн 28-р хуудсыг үз):

- Дууны өгүүлбэр бүрд зориулж цаас бэлтгэж, цаас бүрийг төлөөлсөн зураг бэлтгэ. Зурагнуудыг өрөөний нэг талд харин цааснуудыг өрөөний нөгөө талд байрлуул. Хэрэв Аврагч тэдний хажууд байгааг тэд

харсан бол тэдний үйлдэл хэрхэн өөрчлөгдөх байсныг хүүхдүүдтэй хамт ярилц. Дууллыг дуулж, зурагнуудыг цаастай тохируулахыг хүүхдүүдээс хүс.

- Таныг зураг руу заах үед тантай хамт дуулахыг хүүхдүүдээс хүс.
- Анги бүрт зогсож дуулах нэг өгүүлбэрийг өгч, анги бүр бүх өгүүлбэрийг дуулах хүртэл өгүүлбэрийг ээлжлэн дамжуул.

Хүүхдүүдийг оролцуулж, дууллыг санахад нь тэдэнд туслах тохиромжтой үйлдлийг ашигла.

“Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг” дууллыг заахдаа дараах санаануудыг ашигла (ХДН, 228–29). Хүүхдүүдээс тэд гэр бүлийнхэндээ хайраа хэрхэн харуулсныг асуу. Тэнгэрлэг Эцэг тэдэнд хайраа хэрхэн харуулсныг асуу. Тэр тэдэнд хайртай учраас энэ үзэсгэлэнт дэлхийг бүтээсэн гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд нэг нэг өгүүлбэрээр дууллыг дуулж өгч, тэднийг өгүүлбэр бүрийг тантай хамт дуулахдаа өгүүлбэрт тохирсон үйлдэл хийхийг урь: шувууд дуулж байна, тэнгэр рүү харж байна, тэдний нүүрэн дээр бороо дусалж байна гэх мэтчилэн. Хоёрдахь

шүлгийг дуулах үедээ хүүхдүүдийг нүд рүүгээ зааж, эрвээхэй шиг нисэж, чихний ард гараа аяган хэлбэртэй болгох зэрэг үйлдэл хийхийг урь. Тэднийг “Тэр амь амьдрал” гэж дуулахдаа өөрийгөө тэвэрч, (“сэтгэл”) гэж дуулахдаа зүрхэн дээрээ гараа тавьж, (“оюун бодол бүхнийг надад өгсөн”) гэхдээ толгойгоо дохиж, (“Би түүний бүтээлд талархаж байна”) гэхдээ толгойгоо гудайлгаад гараа хумхихыг урь. Тэднээс “Бурхан надад хайртайг би мэднэ” гэж дуулахдаа зүрхэн дээрээ гараа тавихыг хүс.

Гэрчил: Хүүхдийн хэсгийн дуунууд дээр байдаг сайн мэдээний үнэнүүдийн тухай хүүхдүүдэд товч гэрчил. Хүүхдүүдэд дуулах нь гэрчлэлээ хуваалцаж, Сүнсийг мэдрэх нэг арга зам гэдгийг ойлгоход нь тусал.



Давталт нь хүүхдүүдэд шинэ дууллыг сурахад нь тусалдаг. Дууллыг шивнэх, аялах, цохилтыг нь алга ташиж үзүүлэх, хэмнэлийг тоглох, босч, суунгаа дуулах зэрэг янз бүрийн арга замаар давт.

Хэрэв Аврагч дэргэд минь байсан бол

Бодлогошронгуй ♩ = 90-100

Үг, хөгжмийг Салли ДеФорд

1. Хэ - рэв Ав - рагч дэр - гэд бай-вал, үйл-дэл минь я - мар байх бол? Хэ-нээс ч
 2. Хэ - рэв Ав - рагч дэр - гэд бай-вал, хэл-дэг үгс минь ямар байх бол? Хэ - рэв
 3. Түү нийг би хар-даг-гүй ч гэ-сэн үр-гэлж на - дад ойр бай - даг Тэр на

и лүү шуд-рага, найр-саг, хүн-дэт - гэл - тэй байх болов уу? Ав - рагч би-дэн-тэй хамт
 үр - гэлж дэр - гэд бай - вал, үгс минь ү - нэн байх болов уу? Хэ - рэв Ав-рагч бай-гааг
 дад их хайр - тай уч - раас дээ-рээс минь харан, хам - гаал - даг Тий-мээс би Ав-рагч дэр

байд-гүй ч, үр-гэлж би-дэнд ойр бай - даг Тий-мээс үр - гэлж Түү-ний дэр - гэд бай-гаа
 хар - вал би сайн мэ-дээ-ний ту - хай Хэ-нээс ч и - лүү хи-чээн-гүй, хүн-дэт-гэл
 гэд минь бай-гааг харж бай - гаа шиг Тийм л эе - л - дэг найр - саг нэ - гэн байх ёс - той

1. 2. шиг үйл-дэх ёс - той. гэд - гийг би мэд - нэ.
 тэй-гээр ярих болов уу?

Copyright © 1991 Салли ДеФорд. Бүх эрх хамгаалагдсан.
 Энэ дууг арилжааны бус зорилгоор гэр орон, сүмд ашиглахын
 тулд хувилан олшруулж болно.
 Энэ тэмдэглэлийг олшруулсан хувь бүр дээр хийх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд заах нь

“Бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно” (3 Нифай 22:13) гэж Аврагч заасан билээ.

Хүүхдийн Хэсгийн удирдагчид бүх хүүхдүүдэд түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ч гэсэн Есүс Христийн сайн мэдээг заах чухал үүрэг хариуцлагатай юм. Хүүхдийн Хэсэг нь хүүхэд бүрийг халуун дотноор угтан, хайрлах, арчлах, хамруулах газар мөн. Ийм уур амьсгалд хүүхдүүд Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн хайрыг ойлгож, мэдрэхэд хялбар бөгөөд Ариун сүнсний нөлөөг илүүтэй мэдрдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хэрхэн туслах тухай **илүү дэлгэрэнгүй мэдээллийг** TNGC, 38–39, мөн disabilities.lds.org вэб сайтаас үзнэ үү.


Хүүхэд бүр Бурханд үнэ цэнэтэй. Хүүхэд бүрд хайр, хүндлэл, дэмжлэг хэрэгтэй.

Хүүхдийн Хэсгийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээг хангахад бусдын зөвлөмжийг ав.

- 1. Хүүхдийн эцэг эхтэй зөвлөлд.** Эцэг эхчүүд хүүхдээ хэнээс ч илүү мэддэг. Хүүхдийнхээ хэрэгцээ, анхаарлыг нь татах, суралцах сайн аргаар хэрхэн хангахыг тэд та нарт заах болно. Жишээ нь, зарим хүүхдүүд зааж байгаа зүйлийг дуу хөгжмөөр, бусад нь түүх, зураг, судар эсвэл хөдөлгөөнөөр илүү сайн сурдаг. Хүүхэд бүрд сайн суралцах арга замуудыг эзэмшүүлэхэд чиглэсэн олон янзын заах арга зүйг ашигла.
- 2. Хүүхдийн Хэсгийн бусад удирдагчид, багш нартай зөвлө.** Хүүхэд бүр Есүс Христийн сайн мэдээнд суралцаж, хайрыг мэдрэх арга замуудыг олохын төлөө залбир, хамтран ажилла.
- 3. Тойргийн зөвлөлтэй зөвлөлд.** Санваартны болон бусад туслах бүлгүүдийн удирдагчид онцгой анхаарал шаардлагатай хүүхдүүдэд хэрхэн туслах талаар янз бүрийн санааг мэддэг байж болно. Нэг тойрогт дээд пристийн бүлэг зожиг зантай хүүхдэд туслан анхаарал тавьж, долоо хоног бүр дэргэд нь суух “Хүүхдийн Хэсгийн өвөөг” санал болгосон байна. (Тэр хүн долоо хоног бүр ирж хичээл дээр сууж болно.) Энэ нь хөвгүүн хичээлдээ анхаарлаа төвлөрүүлж, хайрыг мэдрэхэд тусална.



Ахлагч М.Расселл Баллард, “Эрхэм үнэт хүүхдүүдтэй ажиллах хүмүүст ариун, уужим сэтгэлтэй үйлчлэгч байх үүрэг хариуцлага оногдуулсан нь ойлгомжтой. Бурхан өнөөгийн хүүхдүүдийг хайраар, итгэлийн гал дөлөөр, тэд хэн бэ гэдгээ мэдэх ойлголтоор дүүрэн байлгахын тулд биднийг томилсон юм” (“Great Shall Be the Peace of Thy Children,” *Ensign*, 1994 оны 4-р сар, 60) гэж заажээ.



Дүрснүүдийг харыхын тулд энд дарна уу.

Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдүүд үзүүлдэнд сайн хариулдаг. Залбирал хийх, чимээгүй болох эсвэл дуу дуулах цаг болоход энд харуулсантай адил дүртэй үзүүлэнгүүдийг ашигла.

Хичээлийг хялбаршуулан заах нь:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ангид хуваалцах цагаа тэдэнд зориулан өөрчлөх хэрэгтэй байж болно. Хичээлийг өөрчилж заах тухай зарим жишээг sharingtime.lds.org-аас үзэж болно.



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.

© 2012 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 10/11. Орчуулгын эрх: 10/11.

2013 Outline for Sharing Time: I Am a Child of God -ын орчуулга. Mongolian. 08994 363

Зураг: 2-р хуудас: NASA/JPL-ын зөвшөөрлөөр од гаригсын зургийг хэвлэв. 4-р хуудас: дэлхийн зураг © Corbis. 15-р хуудас: үүлний зураг © Getty Images

MONGOLIAN

